



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД БОЛОВСРУУЛСАН
“ХОЁР ЖИВАА ХАРГАА” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ ЗОРИЛТОТ
ТҮВШИНД ХҮРЭЭГҮЙ, ҮР ДҮНГ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛД ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН, ХОЁР ЖИВАА ХАРГАА
ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД 2023-2024 ОНД УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС ОЛГОСОН
ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: УВА-2025/50-ШТА-ГА

Улаангом хот 2025 он

Дарга, тэргүүлэх аудитор **М.Батсуурь**

Утас: 70453317 Цахим хаяг: batsuurim@audit.gov.mn

Аудитын менежер **М.Бат-Амгалан**

Утас: 70453317 Цахим хаяг: batamgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор **Б.Авирмэд**

Утас: 70453317 Цахим хаяг: avirmedb@audit.gov.mn

Аудитор **Р.Аюуш**

Утас: 70453317 Цахим хаяг: ayushr@audit.gov.mn

Аудитор **Т.Батсүх**

Утас: 70453317 Цахим хаяг: batsukht@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтэн мэдээллийн жагсаалт	4
Графикийн жагсаалт	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5
Ерөнхий мэдээлэл	6
Бүлэг1 “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГДСЭН БОДЛОГЫГ ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.	7
1.1 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан байна.	7
1.1.1 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хүрээнд баталсан “Хоёр живаа харгаа” хөтөлбөр нь аймгийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан байна.	7
1.1.2 Холбогдох баримт бичигт нийцүүлэн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг орон нутагт хэрэгжүүлэх стратеги, төлөвлөгөөг баталсан байна.	9
1.1.3 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд 2023-2024 онд улс, орон нутгийн төсвөөс 1,562,288.8 мянган төгрөг баталсан байна.	11
Бүлэг2 ТӨСӨВ САНХҮҮ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХҮРЭЛЦЭЭГҮЙ БАЙДЛААС ШАЛТГААЛЖ “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН, “ХОЁР ЖИВАА ХАРГАА” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ ЗОРИЛТОТ ТҮВШИНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА.	14
2.1 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд улс, орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.	14
2.1.1 Орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан байна.	14
2.1.2 Хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.	18
2.1.3 “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд тарихаар төлөвлөсөн модны 2023, 2024 оны гүйцэтгэл 8.8 хувьтай байна.	22
2.2 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хэрэгжилтийг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлсэн байна.	26
2.2.1 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан байна.	26
2.2.2 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд ил тод мэдээлсэн байна.	30
Бүлэг3 “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЖ, ҮР ДҮНГ ТООЦОЖ БАЙГАА Ч АЙМГИЙН ИТХ-д ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА.	33
3.1 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн үр дүн, хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлж, аймгийн ИТХ-д тайлагнаагүй байна.	33
3.1.1 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хүрээнд сум, байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийсэн ч, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.	33
3.1.2 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн үр дүнг тооцсон ч аймгийн ИТХ-д тайлагнаагүй байна.	35
3.2 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд бий болсон хөрөнгө, тарьц суулгацыг НББ-д бүртгээсэн ч цахим нэгдсэн системд бүрэн бүртгээгүй байна.	3

3.2.1	<i>“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна.</i>	36
3.2.2	<i>Иргэн, ААН, байгууллагуудын тарьсан модыг улсын нэгдсэн санд бүртгэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.</i>	38
Дүгнэлт		40
Холбогдох байгууллагын санал		41-42
Холбогдох байгууллагын ирүүлсэн саналд өгөх тайлбар		43
Зөвлөмж		44

ТОВЧИЛСОН УГИЙН ТАЙЛБАР

ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
УТХГНХЗ	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа
СДОА	Сум дундын ойн анги
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ХААХ	Худалдан авах ажиллагааны хэлтэс
БОГ	Байгаль орчны газар
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ЗГХА	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ХХНТХГНХЗ	Хан хөхий нурууны тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа
ААН	Аж ахуй нэгж
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МУИС	Монгол улсын их сургууль
НББ	Нягтлан бодох бүртгэл

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. "Хоёр живаа харгаа" хөтөлбөр аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр уялдсан байдал	8
Хүснэгт 2. Ойн менежментийн төлөвлөгөө батлуулсан сумдын мэдээлэл	10
Хүснэгт 3. Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Хоёр живаа харгаа" хөтөлбөрийн хүрээнд 2023-2024 онуудад улс, орон нутгаас баталсан төсөв.	12
Хүснэгт 4. Аймгийн хэмжээнд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Хоёр живаа харгаа" хөтөлбөрийн хүрээнд 2023 онд орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгө оруулалт худалдан авах ажиллагаа	14
Хүснэгт 5. Аймгийн хэмжээнд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Хоёр живаа харгаа" хөтөлбөрийн хүрээнд 2024 онд орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагаа	16
Хүснэгт 6. Увс аймгийн хэмжээнд Улсын төсвөөс 2023-2024 онуудад ойжуулалтын ажилд зарцуулсан хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагаа	17
Хүснэгт 7. Ойн чиглэлээр улсын төсвөөс зарцуулсан төсөв	19
Хүснэгт 8. Аймгийн ИТХ-аар батлагдсан арга хэмжээний гүйцэтгэл	19
Хүснэгт 9. Сумдын орон нутгийн төсвөөс зарцуулсан төсөв	20
Хүснэгт 10. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	21
Хүснэгт 11. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал	21
Хүснэгт 12. Хөтөлбөрийн 2023-2024 онд тарих модны төлөвлөгөө, гүйцэтгэл, ургалтын хувь	23
Хүснэгт 13. Байгууллага, сумдын ирүүлсэн тайлбар санал	24
Хүснэгт 14. "Хоёр живаа харгаа" хөтөлбөрийн хүрээнд 2023-2024 онд бэлтгэсэн тарьц суулгацын тоо	24
Хүснэгт 15. Судалгааны дүн мэдээний тулгалт	25
Хүснэгт 16. Сургалтад хамрагдсан төсөвт байгууллага, ААН, иргэдийн тоог	26
Хүснэгт 17. Төсөвт байгууллага, сумдын мод тарих, холбогдох бусад чиглэлээр байгууллага, ААН, иргэдийг соён гэгээрүүлэх сургалт, нөлөөллийн ажил	27
Хүснэгт 18. Улаангом Политехник коллежийн төгсөгчдийн тоо, мэдээ	30
Хүснэгт 19. Иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэсэн тоо, мэдээ	30
Хүснэгт 20. Мод тарих болон холбогдох бусад чиглэлээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэсэн тоо	31
Хүснэгт 21. Ойн чиглэлээр 2023-2024 онуудад хийсэн хяналт, шалгалтаар илрүүлсэн зөрчилд авсан арга хэмжээ	34
Хүснэгт 22. Ойн чиглэлээр 2023- 2024 онд хийсэн хяналтад зарцуулсан төсөв	35
Хүснэгт 23. Хөрөнгийн нягтлан бодох бүртгэлд тусгасан байдал	37
Хүснэгт 24. Сум дундын ойн ангиуд тайлант онуудад үндсэн хөрөнгөд бүртгэсэн дүн	38

ГРАФИК

График 1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	21
График 2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал	22

ЗУРАГ

Зураг 1. Terbummod.mn сайтад	39
------------------------------	----

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/108 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, А/107 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг үндэслэн Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд 2023-2024 онд улс, орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх хууль эрхзүйн орчин бүрдэж, нэгдсэн бодлогыг орон нутгийн түвшинд төлөвлөсөн эсэх;
- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд улс, орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэл зорилтот түвшинд хүрсэн эсэх;
- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд улс, орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүнд хяналт хэрэгжүүлж, үнэлж байгаа эсэх асуудлыг тус тус хамруулсан.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, Байгаль орчны газар, Сум дундын ойн ангиуд, Хан-Хөхийн нурууны улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, Увс нуурын ай сав тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа захиргаа, Худалдан авах ажиллагааны газар, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал болон тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгчид хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг хамруулсан.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудит стандартын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Гүйцэтгэлийн аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж, ахлах аудитор Б.Авирмэд, аудитор Р.Аюуш, Т.Батсүх нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын дүн

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд 2023-2024 онд улс, орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн аудитаар 4 зөвлөмж өглөө.

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 350 дугаар тогтоолоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээг баталсан байна. Хөтөлбөрийг 2021-2030 онд хэрэгжүүлснээр 2022-2024 он хүртэл 150.0 сая, 2027 он хүртэл 850.0 сая, 2030 он хүртэл 1.0 тэрбум мод тарихаар төлөвлөжээ.

Увс аймгийн хэмжээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 7/04 дүгээр тогтоолоор “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийг баталсан байна.

Уг хөтөлбөр нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж нэмэгдүүлэх, цөлжилт, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор 2030 он гэхэд 20.0 саяас доошгүй мод, бут, сөөг тарьж, ойн сангийн талбайн хэмжээг 0.4 хувиар нэмэгдүүлэх зорилготой байна.

БҮЛЭГ 1

**“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
НЭГДСЭН БОДЛОГЫГ ОРОН НУТГИЙН ТҮВШИНД
ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.**

**1.1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны
төлөвлөгөөг боловсруулсан байна.**

**1.1.1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд баталсан “Хоёр живаа
харгаа” хөтөлбөр нь аймгийн урт, дунд хугацааны бодлогын баримт
бичигтэй уялдсан байна.**

Монгол Улсын Ерөнхийлөгч эх дэлхий, байгаль орчноо хайрлан, түүнтэй зохицон амьдрах Монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, эко системийн тэнцвэрт байдлыг хадгалах, ой усны нөөцийг хамгаалж нэмэгдүүлэх зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлж, цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаарх “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигийг гаргасан байна.

Монгол Улсын Засгийн газар Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр 350 дугаар тогтоолын хавсралтаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний 5 зорилт, 39 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг баталсан байна. Мөн Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолын хавсралтад заасан арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг хагас жил тутам нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, холбогдох сайд нарт тус тус даалгасан байна.

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа-2050” хөтөлбөрийн 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 6.2.4-т “Ойжуулах, ойн тэлэн ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, ой хамгааллын арга хэмжээ авах замаар ойн хомсдолоос сэргийлэн, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нийт газар нутгийн 9 хувьд хүргэж, нүүрсхүчлийн хийн шингээлтийг нэмэгдүүлнэ” гэж заасан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч НҮБ-ын Ерөнхий ассамблейн 76 дугаар чуулганд “Улс орон бүр уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулахын зэрэгцээ 2030 он гэхэд Монгол улс тэрбумаар тоологдох хэмжээний мод тарина” гэсэн амлалт өгсөн.

Үүний хүрээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн хэрэгжиж эхэлсэн ба Увс аймаг “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийг боловсруулсан байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 35 дугаар зүйлийн 35.1.8, 35.1.17, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 58 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 350 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 7/04 дүгээр тогтоолоор “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх, Увс аймгийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж нэмэгдүүлэх,

цөлжилт, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор аймгийн хэмжээнд 2030 он гэхэд 20.0 саяас доошгүй мод, бут, сөөг тарьж, ойн сангийн талбайн хэмжээг 0.4 хувиар нэмэгдүүлэх зорилго тавьж, 5 бүлэг 9 зорилт 30 дэд зорилт бүхий “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийг баталсан байна.

Хүснэгт 1. “Хоёр живаа харгаа” хөтөлбөр аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр уялдсан байдал

№	“Хоёр живаа харгаа” хөтөлбөр		Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
	Ерөнхий зорилт	Дэд зорилт		
1	Удирдлага зохион байгуулалт, эрх зүйн баримт бичиг боловсруулах	3	Зорилт 1.1.8 Зорилт 5.4.3	
2	Үр болон тарьц суулгацын нөөц бүрдүүлэх	4	Зорилт 5.4.5	Зорилт 8.3.13
3	Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбай нэмэгдүүлэх, ойжуулалт, ойн зурвас байгуулах ажлыг зохион байгуулах	6	Зорилт 5.4.5	Зорилт 2.5.2 Зорилт 2.5.5 Зорилт 8.1.5
4	Дэвшилтэт технологи, техник багаж хэрэгсэл, үйлдвэрлэлийг бий болгох	1	Зорилт 5.4.5	Зорилт 2.4.2
5	Мод тарьж ургуулах, хамгаалах соёлыг сурталчлан таниулж, мэргэжлийн зөвлөмж, сургалтыг өргөн хүрээнд зохион байгуулах	4	Зорилт 5.4.5	Зорилт 6.2.2
6	Үр, тарьц, суулгац, усан хангамж, мод үржүүлгийн газарт, арчилгаа, хамгаалалт хийх мэргэжлийн байгууллага, хүний нөөцийг нэмэгдүүлэх	5	Зорилт 2.6.4 Зорилт 5.4.5	Зорилт 2.4.2 Зорилт 8.1.5 Зорилт 6.2.3 Зорилт 6.2.4 Зорилт 6.2.5
7	Байгалийн нөөц ашиглагч иргэн, аж ахуй нэгжийг мод тарих ажилд татан оролцуулах	2	Зорилт 5.4.5	Зорилт 6.2.2
8	Санхүүжилтийн тогтвортой механизмыг бий болгох	3	Зорилт 5.4.5	Зорилт 6.4.2
9	Мод тарьж ургуулсан, түүнчлэн дэвшилтэт арга технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах	2	Зорилт 5.4.1 Зорилт 5.4.5	Зорилт 2.6.1
Дүн		30	12	14

Эх сурвалж: Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

“Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн 30 дэд зорилт нь Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, “Увс аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн зорилттуудтай дээрх байдлаар уялдсан байна.

Увс аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар бүлэгт “Ногоон хөгжлийн бодлого”-ыг хэрэгжүүлэхдээ

“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална”, “Хот орчмын орон нутгийн хамгаалалттай газарт таримал ойн төгөл, ногоон зурвас байгуулж, жилд ойжуулах талбайг нэмэгдүүлж, тарьц, суулгацын нөөц бүрдүүлнэ” гэж заасан байна. Мөн аймгийн ИТХ-ын 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 7/03 дугаар тогтоолоор Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулан “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 4/01 дүгээр тогтоолоор “Увс аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг баталсан байна. Энэхүү үндсэн чиглэлийг Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого “Алсын хараа-2050”, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлсэн байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, “Увс аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-тэй уялдуулан орон нутгийн төсвөөс 2023 онд 723,914.4 мянга, 2024 онд 664,957.0 мянган төгрөгийг “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хэрэгжилтэд зарцуулахаар аймаг, сумдын ИТХ-аар баталсан байна.

Түүнчлэн аймгийн Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулсан гэрээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үүднээс 7 зорилтыг дэвшүүлэн хагас, бүтэн жилээр гэрээний биелэлтийг гарган хүргүүлж байна.

1.1.2. Холбогдох баримт бичигт нийцүүлэн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг орон нутагт хэрэгжүүлэх стратеги, төлөвлөгөөг баталсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг тус тус үндэслэн гаргасан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигаар Эх дэлхий, байгаль орчноо хайрлан зохицон амьдрах монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлж, хэрэгжүүлэхийг зарлиг болгосон байна.

Дээрх зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээг батлахдаа 2021-2030 онд хэрэгжүүлснээр 2022-2024 он хүртэл 150.0 сая, 2027 он хүртэл 850.0 сая, 2030 он хүртэл 1.0 тэрбум мод тарихаар төлөвлөжээ.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн төслийг 2021 онд аймгийн Байгаль орчны газар, Өндөрхангай, Түргэн, Малчин сумдын Сум дундын ойн анги, Бүс орон нутаг, хөрөнгө оруулалт, хөгжлийн

бодлогын хэлтэс хамтран боловсруулсан байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр байгаль орчны салбарын байгууллагууд, сумдын удирдлага, байгаль орчны мэргэжилтнүүд, идэвхтэн байгаль хамгаалагч зэрэг нийт 150 хүний бүрэлдэхүүнтэй “Хоёр живаа харгаа” зөвлөгөөнийг зохион байгуулжээ. Тус зөвлөгөөнөөр “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн төслийг танилцуулан хэлэлцүүлж оролцогчдоос гарсан саналыг нэгтгэн төсөлд тусгасан байна.

“Хоёр живаа харгаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний Зорилт 1-т “Удирдлага зохион байгуулалт эрхзүйн баримт бичиг боловсруулах”, 1.3-т “Сумууд, төрийн болон албан байгууллагууд хөтөлбөрийн менежмент төлөвлөгөөг жил бүр боловсруулах, тайлагнах” гэж заасан байна.

Энэ хүрээнд батлагдсан хөтөлбөрийг сум, холбогдох байгууллагад хүргүүлсэн ба хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг дарга, Байгаль орчны газраас 2023, 2024 оны хавар, намар мод тарих арга хэмжээний төлөвлөгөө, удирдамжийг албан бичгээр сумдын Засаг дарга нарт хүргүүлжээ. Түүнчлэн аймагт мод, бут, сөөгийн тарьц, суулгац бэлтгэн нийлүүлж буй иргэд, аж ахуйн нэгжүүдийн судалгаа, тарьц суулгацын нэр төрөл, тоо, утасны дугаар үнэ зэрэг мэдээллийг хүргүүлж ажилласан байна.

Сумууд “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн менежмент төлөвлөгөөг тусгайлан боловсруулаагүй ба 11 сум ойн менежментийн төлөвлөгөө боловсруулж сумын ИТХ-аараа батлуулсан ба 4 сум батлуулаагүй, ойн сангүй 4 сум байна. Ойн менежментийн төлөвлөгөө батлуулсан сумдын мэдээллийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Ойн менежментийн төлөвлөгөө батлуулсан сумдын мэдээлэл

№	Сумын нэр	Хариуцаж буй ойн анги	Төлөвлөгөө баталсан	
			Огноо	ИТХ-ын тогтоолын дугаар
1	Баруунтуруун	Өндөрхангай	2024.02.26	11
2	Бөхмөрөн	Түргэн	2024.02.23	13/02
3	Давст	Түргэн	2024.09.25	18/04
4	Завхан	байхгүй	шаардлагагүй	
5	Зүүнговь	Малчин	шаардлагагүй	
6	Зүүнхангай	Өндөрхангай	2023.12.18	15/01
7	Малчин	Малчин		
8	Наранбулаг	Малчин		
9	Өлгий	байхгүй	шаардлагагүй	
10	Өмнөговь	Түргэн	шаардлагагүй	
11	Өндөрхангай	Өндөрхангай	2023.12.12	17/10
12	Сагил	Түргэн	2024.04.25	14/08
13	Тариалан	Түргэн	2024.02.27	15/05
14	Түргэн	Түргэн	2024.12.24	03/07
15	Тэс	Малчин		
16	Ховд	Түргэн	2024.06.05	17/03
17	Хяргас	Малчин		
18	Цагаанхайрхан	Өндөрхангай	2023.12.13	15/08
19	Улаангом	Түргэн	2024.03.18	19/03

Эх сурвалж: Сумын ИТХ-ын тогтоол

Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно”, 3.1.6 дахь заалтад “ойн менежментийн төлөвлөгөө” гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх, эсхүл эзэмшлийн ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн ойн

аж ахуйн арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг цогц байдлаар, тодорхой үе шаттайгаар тусгаж, төлөвлөсөн баримт бичгийг” гэж заажээ

Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт “Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 17.2.10 дахь заалтад “Ой бүхий сум, дүүргийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих” гэж заасан ч аймгийн Засаг дарга сумдын ойн менежментийн төлөвлөгөөг батлаагүй байна.

Цаашид ой бүхий сумын ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих талаар сумдад чиглэл хүргүүлж тодорхой ажлыг үе шаттайгаар зохион байгуулахыг холбогдох албан тушаалтанд зөвлөмж болголоо.

1.1.3 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд 2023-2024 онд улс, орон нутгийн төсвөөс 1,562,288.8 мянган төгрөг баталсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолын хавсралтын 3-т “Төсөв, санхүүгийн нөөцийг бүрдүүлж, шийдвэрлэх” гэж заажээ. Үүнд:

- ✚ Ойн салбарын бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах төрийн захиргааны байгууллага болон Монгол орны байгалийн бүс, бүслүүр, хөрс, цаг агаарын онцлогт тохирсон мод, бутыг тарьж ургуулах, арчлан хамгаалах үүрэг бүхий ойн аж ахуйн төвүүдийг бүсчлэн байгуулж, холбогдох санхүүжилтийг шийдвэрлэх.
- ✚ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авах.
- ✚ Модны аж ахуйн цогцолбор үйлдвэрүүдийг бүсчлэн байгуулж, кластерын зарчмаар хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийг хөнгөлөлттэй зээл хэлбэрээр шийдвэрлэх.
- ✚ Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, гадаадын зээл тусламжийг татан төвлөрүүлэх, хүлэмжийн хийн зах зээлээс хөрөнгө босгохтой холбоотой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх.

“Хоёр живаа харгаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний Зорилт 8-д “Санхүүжилтийн тогтвортой механизмыг бий болгох” гэж заажээ. Үүнд:

- ✚ Жил бүр орон нутгийн хөгжлийн сангийн 3-аас доошгүй хувийг “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх.
- ✚ Төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах.
- ✚ “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хууль, Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 2 дугаар тогтоол “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын 85 хувийг ойг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд 2023-2024 онуудад улс, орон нутгийн төсвөөс 1,562,288.8 мянган төгрөгийг баталсан байна.

**Хүснэгт 3. Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд
2023-2024 онуудад улс, орон нутгаас баталсан төсөв.**

(Мянган төгрөг)

№	Сум, Байгууллагын нэр	Батлагдсан төсөв, эх үүсвэр /2023 он/				2023 оны нийт батлагдсан төсөв	Батлагдсан төсөв, эх үүсвэр /2024 он/			2024 оны нийт батлагдсан төсөв	2023-2024 нийт батлагдсан төсөв
		Улсын төсөв	ОНХС	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	Орон нутгийн хөрөнгө оруулалт		Улсын төсөв	ОНХС	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Аймгийн ЗДТГ		117,003.0		93,121.8	210,124.8		199,000.0		199,000.0	409,124.8
2	Байгаль орчны газар	2,047.0				2,047.0	5,354.8			5,354.8	7,401.8
3	Өндөрхангай ханхөхий нурууны УТХГНХЗ	14,000.0				14,000.0	11,000.0			11,000.0	25,000.0
4	Увс нуурын ай савын УТХГНХЗахиргаа	986.2	-	-	-	986.2	2,303.7	-	-	2,303.7	3,289.9
5	Өндөрхангай СДОА	18,915.0				18,915.0	14,223.0			14,223.0	33,138.0
6	Малчин СДОА	11,064.1	-	-	-	11,064.1	8,717.4	-	-	8,717.4	19,781.5
7	Түргэн СДОА	37,197.0	-	-	-	37,197.0	55,011.0	-	-	55,011.0	92,208.0
8	Баруунтуруун сум			17,487.1		17,487.1			19,975.0	19,975.0	37,462.1
9	Бөхмөрөн сум	-	5,760.0	7,153.5	-	12,913.5	-	20,000.0	1,967.0	21,967.0	34,880.5
10	Давст сум		65,000.0	6,797.0		71,797.0		8,000.0	5,727.5	13,727.5	85,524.5
11	Завхан сум	-	5,700.0	-	-	5,700.0	-	-	-	-	5,700.0
12	Зүүнговь сум		43,190.0	560.0		43,750.0		41,630.0	495.0	42,125.0	85,875.0
13	Зүүнхангай сум		90,000.0	9,800.0		99,800.0			13,904.2	13,904.2	113,704.2
14	Малчин сум		15,000.0	28,018.9		43,018.9		7,000.0	12,495.2	19,495.2	62,514.1
15	Наранбулаг сум		6,000.0	9,033.1		15,033.1		40,000.0	5,000.0	45,000.0	60,033.1
16	Өлгий сум		3,000.0			3,000.0				-	3,000.0
17	Өмнөговь сум					-		2,500.0	5,780.0	8,280.0	8,280.0
18	Өндөрхангай сум			22,000		22,000.0			62,352	62,352.3	84,352.3
19	Сагил сум			19,317.2		19,317.2			14,155.0	14,155.0	33,472.2
20	Тариалан сум	-	7,141.0	1,249.0	-	8,390.0	-	18,990.0	680.0	19,670.0	28,060.0
21	Түргэн сум	-	-	10,936.0	-	10,936.0	-	-	8,420.0	8,420.0	19,356.0
22	Тэс сум	-	62,100.0	5,476.3	-	67,576.3	-	3,600.0	4,250.0	7,850.0	75,426.3
23	Хяргас сум		15,000.0	16,830.9		31,830.9		18,050.0	16,206.5	34,256.5	66,087.4
24	Ховд сум			7,270.6		7,270.6		12,069.5		12,069.5	19,340.1
25	Цагаанхайрхан сум	-	-	3,000.0	-	3,000.0	-	-	11,200.0	11,200.0	14,200.0
26	Улаангом сум			28,922.0		28,922.0		60,000.0	46,155.0	106,155.0	135,077.0
	Нийт	84,209.3	434,894.0	193,851.6	93,121.8	806,076.7	96,609.9	430,839.5	228,762.7	756,212.1	1,562,288.8

*Эх сурвалж: Увс аймаг дахь Төрийн аудитын газрын нэгтгэсэн судалгаа,
ИТХ-ын тогтоол*

Дээрх хүснэгтээс харахад хөтөлбөрийн хүрээнд 2023 онд улсын төсөвт байгууллагын ойн чиглэлийн үйл ажиллагааны зардалд 84,209.3 мянга, Орон нутгийн хөгжлийн сангаас 434,894 мянга, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 193,851.6 мянга, Орон нутгийн хөрөнгө оруулалтаас 93,121.8 мянга, нийт 806,076.7 мянган төгрөг, 2024 онд Улсын төсөвт байгууллагын ойн чиглэлийн үйл ажиллагааны зардалд 96,609.9 мянга, Орон нутгийн хөгжлийн сангаас 430,839.5 мянга, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 228,762.7 мянга, нийт 756,212.1 мянган төгрөгийн төсөв тус тус баталсан байна.

Увс аймгийн Байгаль орчны газар, Ханхөхий нурууны УТХГНХЗ, Увс нуурын ай савын УТХГНХЗ, Өндөрхангай, Малчин, Түргэн сумын СДОА зэрэг 6 төсөвт байгууллага “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд 2023 онд 84,209.3 мянга, 2024 онд 96,609.9 мянга, нийт 180,819.2 мянган төгрөгөөр ойн чиглэлийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд Орон нутгийн хөгжлийн сангаас 2023 онд 434,894.0 мянга, 2024 онд 430,839.5 мянга, нийт 865,733.5 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

“Хоёр живаа харгаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний Зорилт 8.1-д “Жил бүр орон нутгийн хөгжлийн сангийн 3-аас доошгүй хувийг “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх” гэж заасны дагуу Баруунтуруун, Өндөрхангай, Сагил, Түргэн, Цагаанхайрхан сумдаас бусад 14 сум тодорхой хэмжээний төсвийг ОНХС-ийн эх

үүсвэрээс зарцуулахаар төлөвлөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан байна.

Цаашид Төсвийн тухай хууль болон Монгол улсын Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д нийцүүлэн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлж ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөлөө.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөр хүрээнд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 93,121.8 мянган төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-аар баталсан байна.

“Хоёр живаа харгаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний Зорилт 8.3-д “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”, Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 2 дугаар тогтоол “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын 85 хувийг ойг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах” гэж заасныг дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 2023 онд 193,851.6 мянга, 2024 онд 228,762.7 мянга, нийт 422,614.2 мянган төгрөгийг зарцуулахаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор баталсан байна.

БҮЛЭГ 2

ТӨСӨВ САНХҮҮ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХҮРЭЛЦЭЭГҮЙ БАЙДЛААС ШАЛТГААЛЖ “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН, “ХОЁР ЖИВАА ХАРГАА” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ ЗОРИЛТОТ ТҮВШИНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА.

2.1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд улс, орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

2.1.1. Орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газраас 2023 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 117,003.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй "Хоёр живаа харгаа" хөтөлбөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ. Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дүгээр сарын 17-ны өдрийн А/197 дугаар захирамжаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасны дагуу "Хоёр живаа харгаа" хөтөлбөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог байгуулан ажилласан байна.

Үнэлгээний хороонд аймгийн Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, тухайн салбарын холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулсан байна.

Мөн "Хоёр живаа харгаа" хөтөлбөр хэрэгжүүлэх /Тэрбум мод үндэсний хөдөлгөөн/-ийг гүйцэтгэх гүйцэтгэгчийг 2023 оны 04 дүгээр сарын 18-нд нээлттэй тендер сонгон шалгаруулалтын аргаар, цахим системээр зарласан байна.

Уг сонгон шалгаруулалтад “Чандмань хархираа” ХХК 117,002.2 мянган төгрөгийн үнийн санал ирүүлснийг үнэлгээний хороо 5 гишүүн тус бүр үнэлээд шаардлагад нийцсэн гэж үзэн дэмжсэн байна.

Хүснэгт 4. Аймгийн хэмжээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд 2023 онд орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагаа

(Мянган төгрөг)

Эх үүсвэр	ХАА зохион байгуулсан нэгж	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	Гүйцэтгэл	ХАА-ны мөрдсөн журам
ОНХС	ОНӨГ-ын ХААХ	"Хоёр живаа харгаа" хөтөлбөр хэрэгжүүлэх /Тэрбум мод үндэсний хөдөлгөөн/	117,003.0	117,002.2	Нээлттэй тендер
Аймгийн Хөрөнгө оруулалт	Зүүнговь сумын ЗДТГ	Зүүнговь сумын төвийн ногоон байгууламж, засвар, тохижилт	90,000.0	85,887.0	Харьцуулалтын арга

Эх сурвалж: ХААГ-ын түүвэр

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид

шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй”, тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэгт “Захиалагчийг төлөөлөх этгээд энэ хуулиар олгогдсон эрх, үүргийг тухайн байгууллагын холбогдох бусад этгээдэд шилжүүлэх нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж заасан байна.

Мөн Засгийн газрын 2023 оны 278 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1-д “Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлэх”, 4.1.1.1-д “Төсвийн тухай хуулийн 14.4-т заасныг үндэслэн төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих эрхийг хэсэгчилж, эсхүл бүхэлд нь шилжүүлэх”, 4.1.1.2-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.6-д заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг шилжүүлэх” гэж заажээ.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжих 1 төсөл, арга хэмжээний эрхийг харьяалах төсвийн захирагчид шилжүүлсэн байна. Үүнд:

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 4-ний өдрийн А/04 дүгээр захирамжаар 1 төсөл, арга хэмжээ:

1. Зүүнговь сумын төвийн ногоон байгууламж, засвар, тохижилт-90,000.0 мянган төгрөг

Зүүнговь сумын Засаг даргын тамгын газарт эрх шилжин ирсэн 90,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Зүүнговь сумын төвийн ногоон байгууламж, засвар, тохижилт”-ын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг хуулийн хүрээнд цахим системээр 2 удаа зарласан байна.

Сонгон шалгаруулалтад “Хүрмээн-Оргил” ХХК 85,887.0 мянган төгрөгийн үнийн санал ирүүлснийг үнэлгээний хороо шаардлагад нийцсэн гэж үзэж дэмжсэн байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газраас 2024 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 150,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Хоёр живаа харгаа” хөтөлбөр хэрэгжүүлэх /Тэрбум мод үндэсний хөдөлгөөн/ төсөл, арга хэмжээний хүрээнд Улаангом Политехник коллежид эх цэцэрлэг байгуулах төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/267 дугаар захирамжаар байгуулан ажилласан байна.

Үнэлгээний хороонд аймгийн Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, тухайн салбарын холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулсан байна.

“Хоёр живаа харгаа” хөтөлбөр хэрэгжүүлэх /Тэрбум мод үндэсний хөдөлгөөн/ төсөл арга хэмжээний хүрээнд Улаангом Политехник коллежид эх цэцэрлэг байгуулах төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг 2024 оны 05 дугаар сарын 17-нд нээлттэй тендер сонгон шалгаруулалтын аргаар, цахим системээр зарласан байна.

Уг сонгон шалгаруулалтад “Чандмань хархираа” ХХК шалгарч үнэлгээний хороо гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг хүргүүлсэн байна.

“Улаангом Политехник коллежид эх цэцэрлэг байгуулах” төсөл, арга хэмжээний ажлын даалгаврыг боловсруулах ажлын хэсэгт Байгаль орчны газрын төлөөллийг оролцуулаагүй байна.

Аймгийн ЗДТГ-ын холбогдох мэргэжилтэн, Улаангом Политехник коллежийн захирал, мэргэжлийн багш нарын боловсруулсан ажлын даалгаварт тарьц суулгац нийлүүлэх гэж заасны дагуу гүйцэтгэгч компани нийт 23 төрлийн 1200 ширхэг тарьц суулгац нийлүүлсэн байна. Тус 1200 ширхэг тарьц суулгацыг Улаангом Политехник коллежийн мэргэжлийн багш, суралцагчид байгууллагын эзэмшлийн талбайд тарьж суулгасан байна.

Ингэснээр Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А-96/71 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын “Гүйцэтгэсэн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь ойжуулсан талбайгаа 3 жилийн хугацаанд арчлан хамгаалж ургуулах” гэсэн заалт хэрэгжих боломжгүй болж байна.

Түүнчлэн гүйцэтгэгч компанийн нийлүүлсэн үхрийн нүднээс бусад 22 төрлийн 500 тарьц суулгац нь тухайн хөрсөнд дасан зохицож ургаагүй тохиолдолд нөхөн тарилтын асуудлыг хэн хариуцах нь тодорхойгүй нөхцөл байдал үүсэж болзошгүй байна.

Иймд ажлын даалгавар боловсруулахдаа мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулж цаашид гарч болох үр дагаврыг тооцож байхыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөлөө.

Хүснэгт 5. Аймгийн хэмжээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд 2024 онд орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагаа

(Мянган төгрөг)

Эх үүсвэр	ХАА зохион байгуулсан нэгж	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	Гүйцэтгэл	ХАА-ны мөрдсөн журам
ОНХС	ХААГ	Тэрбум мод үндэсний хөтөлбөр, "Хоёр живаа харгаа" төслийн хүрээнд Улаангом Политехник коллежид эх цэцэрлэг байгуулах	150,000.0	150,000.0	Нээлттэй тендер
	БОАЖГ	Ойн зурвасын талбайд гүний худаг бүхий цахилгааны шугам татах /Улаангом сум/	49,000.0	48,098.1	Харьцуулалтын арга

Эх сурвалж: ХААГ-ын түүвэр

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжих 1 төсөл, арга хэмжээний эрхийг харьяалах төсвийн захирагчид шилжүүлсэн байна. Үүнд:

Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/559 дүгээр захирамжаар:

1. Ойн зурвасын талбайд гүний худаг бүхий цахилгааны шугам татах /Улаангом сум/ - 49,000.0 мянган төгрөг

Аймгийн Байгаль орчны газарт эрх шилжин ирсэн 49,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Ойн зурвасын талбайд гүний худаг бүхий цахилгааны шугам татах /Улаангом сум/” ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг цахим системээр 3

удаа зарласан байна.

Уг сонгон шалгаруулалтад “Оточ эрчим” ХХК шалгарч үнэлгээний хороо гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Аудитад хамрагдсан 2023 онд мөрдөгдөж байсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5 дэх хэсэгт “Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг захиалагч тухайн жилийн 12 дугаар сарын 1-ний дотор төсвийн ерөнхийлөн захирагчид, ерөнхийлөн захирагч нь дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана” Сангийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 102 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, 2024 оноос мөрдөгдөж эхэлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр тайлагнана”, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу аймгийн Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газруудаас Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023, 2024 оны худалдан авах ажиллагааны тайланг гаргаж www.user.tender.gov.mn системээр баталгаажуулан Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газарт хуулийн хугацаанд хүргүүлсэн байна.

Мөн хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэгт “Захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулах бүрд тендер шалгаруулалтын хувийн хэрэг бүрдүүлж, түүнд дараах баримт бичгийг хавсаргана”, 48.5 дахь заалтад “Тендер шалгаруулалтын хувийн хэргийг архивын нэгж болгон хадгална” гэсэн заалтын дагуу тендерийн материалыг архивын нэгж болгосон байна.

Аудитад хамрагдах онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3 суманд 404,775.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ойжуулалтын ажил хийгдсэн байна.

Хүснэгт 6. Увс аймгийн хэмжээнд Улсын төсвөөс 2023-2024 онуудад ойжуулалтын ажилд зарцуулсан хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагаа

(Мянган төгрөг)

Эх үүсвэр	ХАА зохион байгуулсан нэгж	Төсөл хэрэгжих огноо	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	Гүйцэтгэл	ХАА-ны мөрдсөн журам
Улсын төсөв	ЗГХА-ын Ойн газар	2023 он	Өлгий сумын ойн зурвас байгуулах 10 га талбайн ойжуулалтын ажил	112,500.0	112,500.0	Нээлттэй тендер
		2024 он	Баруунтуруун сумын 10 га талбайн ойжуулалтын ажил	176,500.0	175,900.0	Нээлттэй тендер
		2024 он	Түргэн сумын Олзот гэх газарт “Шилмүүст модны тарьцаар ойжуулах” 40 га талбайн ажил	115,775.0	115,775.0	Нээлттэй тендер
Нийт дүн				404,775.0	404,175.0	

Эх сурвалж: *tender.gov.mn*

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн дээрх 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газраас нээлттэй тендер сонгон шалгаруулалтын аргаар цахим системээр зарласан байна.

2.1.2. Хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолоор баталсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 13-д “Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авах” гэж тусгасан байна.

“Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дараах хөрөнгийн эх үүсвэрийг ашиглахаар тусгажээ. Үүнд:

-  Улсын төсөв
-  Орон нутгийн төсөв
-  Аж ахуйн нэгж, байгууллага, хоршоо, нөхөрлөл, иргэний өөрийн хөрөнгө
-  Дотоодын болон олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө, тусламж
-  Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив зэрэг болно.

Улсын болон орон нутгийн төсвөөс гаргах хөрөнгийг аймаг, сумын тухайн жилийн төсвийн төсөлд тусгаж санхүүжүүлнэ гэж заасан байна.

Тайлант онуудад улс, орон нутгийн төсвөөс зарцуулсан санхүүжилт, хэрэгжсэн төсөл, арга хэмжээний мэдээлэл дараах байдалтай байна.

➤ Улсын төсөв:

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн дараах төсөл арга хэмжээнүүд нь эрх шилжиж ирээгүй Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон ойн газраас шууд хэрэгжүүлсэн байна.

- Баруунтуруун суманд “Бага Монгол Импекс” ХХК-ийн гүйцэтгэсэн 175.9 сая төгрөгийн гэрээтэй ойжуулалт хийх 2024 он,
- Өлгий суманд “Цагаан эрэг-Ногоон алт” ХХК-ийн гүйцэтгэсэн 112.5 сая төгрөгийн гэрээтэй хамгаалалтын ойн зурвас байгуулах 2023 он,
- Түргэн суманд “Түргэн сум дундын ойн анги”-ийн гүйцэтгэсэн 115.8 сая төгрөгийн гэрээтэй шилмүүст модны тарьцаар ойжуулах 2024 он,
- Өндөрхангай, Зүүнхангай, Малчин, Наранбулаг суманд ойн хортон шавжийн тэмцлийн ажил 4000 га-д хийх 160.0 сая төгрөгийн төсөвтэй 2023 он
- Ойн сан бүхий 9 суманд ойн хортон шавжтай тэмцэх ажил 40500 га талбайд хийх 1.296.0 сая төгрөгийн төсөвтэй 2024 он,
- Улаангом суманд цөлжилттэй тэмцэх ногоон байгууламж 359.8 сая төгрөг /2022, 2023 онд он дамжин хэрэгжсэн/

Түүнчлэн улсын төсвөөс санхүүждэг гурван сум дундын ойн анги, 2 тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны зүгээс байгалийн сэргэн ургалтыг дэмжих замаар доройтсон ойг нөхөн сэргээх, үр, суулгацын нөөц бүрдүүлэх, түймэр, хөнөөлт шавж, хууль бус мод бэлтгэл зэргийг бууруулах ой хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх, ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн нийтийн эрүүл мэндэд үзүүлэх ач холбогдол, нөлөөллийн талаар олон нийтэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах, ойжуулалт, мод тарьж ургуулах асуудлыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, соён гэгээрүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулахад батлагдсан төсвөөс тодорхой зардлууд гаргасан байна.

Хүснэгт 7. Ойн чиглэлээр улсын төсвөөс зарцуулсан төсөв

(Мянган төгрөг)

№	Сум, Байгууллагын нэр	Гүйцэтгэл		Нийт дүн
		2023 он	2024 он	
1	Байгаль орчны газар	2,047.0	5,354.8	7,401.8
2	Ханхөхий нурууны УТХГНХЗ	14,000.0	11,000.0	25,000.0
3	Увс нуурын ай савын УТХГНХЗ	986.2	2,303.7	3,289.9
4	Өндөрхангай СДОА	18,915.0	14,223.0	33,138.0
5	Малчин СДОА	11,064.1	8,717.4	19,781.5
6	Түргэн СДОА	37,197.2	55,011.0	92,208.2
Дүн		84,209.5	96,609.9	180,819.4

Эх сурвалж: Аудитын түүвэр, судалгаа

Байгаль орчны газар, Ханхөхий нурууны УТХГНХЗ, Увс нуурын ай савын УТХГНХЗ нь сургалт нөлөөлөл болон хяналт шалгалтын ажилд өөрийн төсвөөс шууд зардал гаргасан байна.

Өндөрхангай, Малчин, Түргэн сумын СДОА-ууд нь тарьц суулгац бэлтгэх, талбай тусгаарлалт хийх, арчилгааны гэрэлжүүлэх, тохируулах огтлолт хийх, сургалт нөлөөллийн ажил зэрэг арга хэмжээнд зардал гаргасан байна.

➤ **Аймгийн төсөв:**

Тайлант онуудад аймгийн ИТХ-аар батлагдсан 4 төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна. Түүнчлэн өмнөх онд хэрэгжсэн 1 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг /техник хяналтын зардал/ олгосон байна.

Хүснэгт 8. Аймгийн ИТХ-аар батлагдсан арга хэмжээний гүйцэтгэл

(Мянган төгрөг)

№	Төсөл арга хэмжээний нэр	Он	Эх үүсвэр	Төсөвт өртөг	Гүйцэтгэл
1	"Наадмын талбайн ногоон байгууламж" ажлын санхүүжилтийн үлдэгдэл	2022	ОНХО	3,121.8	2,351.9
2	"Хоёр живаа харгаа" хөтөлбөр хэрэгжүүлэх /Тэрбум мод үндэсний хөдөлгөөн/	2023	ОНХС	117,003.0	117,002.2
3	Зүүнговь сумын төвийн ногоон байгууламж, засвар, тохижилт	2024	ОНХО	90,000.0	85,887.0
4	"Хоёр живаа харгаа" хөтөлбөр хэрэгжүүлэх /Тэрбум мод үндэсний хөдөлгөөн/	2024	ОНХС	150,000.0	150,000.0
5	Ойн зурвасын талбайд гүний худаг бүхүй цахилгааны шугам татах /Улаангом сум/	2024	ОНХС	49,000.0	48,098.1
Дүн				409,124.8	403,339.3

Эх сурвалж: Аудитын түүвэр, судалгаа

Дээрх төсөл, арга хэмжээнүүд нь бүрэн хэрэгжиж дууссан ба аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан комисс хүлээн авч акт үйлдсэн байна.

➤ **Сумын төсөв:**

Тайлант онуудад сумд ОНХС болон Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас тарьц суулгац худалдан авах, мод тарих, арчлах, хашаа хайс барих, түймэр, хөнөөлт шавж, хууль бус мод бэлтгэл зэргийг бууруулах ой хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх, мод тарьж ургуулах асуудлыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 9. Сумдын орон нутгийн төсвөөс зарцуулсан төсөв

(Мянган төгрөг)

№	Сумын нэр	2023 онд зарцуулсан төсөв		2024 онд зарцуулсан төсөв		Нийт зарцуулсан төсөв
		ОНХС	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	ОНХС	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	
1	Баруунтуруун сум		16,580.0		19,975.0	36,555.0
2	Бөхмөрөн сум	5,760.0	7,153.5	19,850.0	2,147.0	34,910.5
3	Давст сум	65,000.0	3,423.30		5,341.90	73,765.2
4	Завхан сум	5,700.0	-	-	-	5,700.0
5	Зүүнговь сум	8,000.0		31,440.0	400.0	39,840.0
6	Зүүнхангай сум	89,350.0	1,183.7		11,920.2	102,453.9
7	Малчин сум	15,000.0	26,018.9	7,000.0	12,795.2	60,814.1
8	Наранбулаг сум		2,761.7	10,760.0	2,410.9	15,932.6
9	Өлгий сум	3,000.0				3,000.0
10	Өмнөговь сум			2,500.0	2,260.0	4,760.0
11	Өндөрхангай сум		9,920.0		59,852.3	69,772.3
12	Сагил сум		7,189.1		7,815.7	15,004.8
13	Тариалан сум	7,141.1	1,248.9	9,948.0	558.5	18,896.5
14	Түргэн сум	-	9,500.0	-	6,920.0	16,420.0
15	Тэс сум	59,413.0	4,493.2	3,600.0	3,879.0	71,385.2
16	Хяргас сум	13,950.0	12,320.6	10,050.0	14,887.5	51,208.1
17	Ховд сум		4,762.9		6,905.0	11,667.9
18	Цагаанхайрхан сум	-	3,000.0	-	8,909.4	11,909.4
19	Улаангом сум		13,290.0	11,000.0	42,358.0	66,648.0
Нийт		272,314.1	122,845.8	106,148.0	209,335.6	710,643.5

Эх сурвалж: Аудитын түүвэр, судалгаа

ОНХС-ийн эх үүсвэрээс 2023 онд 10 сум 272,314.1 мянга, 2024 онд 9 сум 106,148.1 мянга, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 2023 онд 15 сум 122,845.8 мянга, 2024 онд 17 сум 209,335.6 мянга, нийт 710,643.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээс сумдын ИТХ-аар батлуулсан төсөл, арга хэмжээнүүдийг санхүүжүүлж хэрэгжүүлсэн байна. Тус төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг тухайн оны санхүүгийн тайлангийн аудит болон ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийсэн байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”, Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 5-ны өдрийн 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын 85 хувийг ойг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулж байна.

Дээрх хууль, журмын хүрээнд Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг дэлгэрэнгүй харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 10. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Сумын нэр	2023 он		Үүнээс гүйцэтгэлээр						
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Мод тарих, тарьц суулгац авах	Хашаа хайс, арчилгаа, усалгаа	Талбай тусгаарлалт	Хяналт шалгалт, ой хээрийн түймрээс сэргийлэх	Сургалт нөлөөлөл	Ойн хортон шавжтай тэмцэх	Арчилгааны огтлолт бусад
1	Баруунтуруун	17,487.1	16,580.0	3,085.0	8,830.0	3,750.0		915.0		
2	Бөхмөрөн	7,153.5	7,153.5	450.0		1,800.0	4,403.5	500.0		
3	Давст	6,797.0	3,423.3	1,500.0	978.3		450.0			495.0
4	Завхан	-	-		-					
5	Зүүнговь	560.0								
6	Зүүнхангай	9,800.0	1,183.7	777.0			153.5	253.2		
7	Малчин	28,018.9	26,018.9	7,250.0	10,000.0			1,808.9	560.0	6,400.0
8	Наранбулаг	9,033.1	2,761.7			1,500.0	1,261.7			
9	Өлгий									
10	Өмнөговь	-	-							
11	Өндөрхангай	22,000.0	9,920.0				9,920.0			
12	Сагил	19,317.2	7,189.1		3,315.0	2,025.0	1,107.2	345.9	396.0	
13	Тариалан	1,248.9	1,248.9			225.0	800.9			223.0
14	Түргэн	10,936.0	9,500.0	5,000.0		4,500.0				
15	Тэс	5,476.3	4,493.2	450.0		2,025.0	1,623.2		395.0	
16	Ховд	7,270.6	4,762.9	2,090.0		1,050.0	1,622.9			
17	Хяргас	16,830.9	12,320.6	1,564.7	1,500.0	4,875.0	3,680.9		700.0	
18	Цагаанхайрхан	3,000.0	3,000.0	2,500.0				500.0		
19	Улаангом	28,922.0	13,290.0	4,961.0	7,704.0		625.0			
Дүн		193,851.5	122,845.8	29,627.7	32,327.3	21,750.0	25,648.8	4,323.0	2,051.0	7,118.0

Эх сурвалж: Аудитын түүвэр, судалгаа




График 1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 2023 онд 193,851.5 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж 122,845.8 мянган төгрөгийн зарцуулсан байна. Үүнээс 26.3%-ийг хашаа, хайс, арчилгаа, усалгаанд, 24.1 %-ийг мод тарих, тарьц суулгац худалдан авахад, 20.9%-ийг хяналт, шалгалт, ой хээрийн түймрээс сэргийлэхэд, 17.7%-ийг талбай тусгаарлалтад, 5.8%-ийг арчилгааны огтлолт, бусад арга хэмжээнд, 3.5%-ийг сургалт нөлөөллийн ажилд, 1.7%-ийг ойн хортон шавжтай тэмцэх ажилд тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 11. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал (Мянган төгрөг)

№	Сумын нэр	2024 он		Үүнээс гүйцэтгэлээр						
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Мод тарих, тарьц суулгац авах	Хашаа хайс, арчилгаа, усалгаа	Талбай тусгаарлалт	Хяналт шалгалт, ой хээрийн түймрээс сэргийлэх	Сургалт нөлөөлөл	Ойн хортон шавжтай тэмцэх	Арчилгааны огтлолт бусад
1	Баруунтуруун	19,975.0	19,975.0	2,250.0		3,750.0	2,225.0	1,750.0	10,000.0	
2	Бөхмөрөн	1,967.0	2,147.0			1,200.0	567.0	380.0		

3	Давст	5,727.5	5,341.9		2,478.3	1,114.6	775.0	200.0		774.0
4	Завхан	-	-			-				-
5	Зүүнговь	495.0	400.0	400.0						
6	Зүүнхангай	13,904.2	11,920.2	3,175.7	550.0		7,974.5	220.0		
7	Малчин	12,795.2	12,795.2	4,500.0	4,000.0	2,250.0	940.4		1,104.8	
8	Наранбулаг	5,000.0	2,410.9			1,500.0	910.9			
9	Өлгий	-	-							
10	Өмнөговь	5,780.0	2,260.0		2,260.0					
11	Өндөрхангай	62,352.3	59,852.3						19,920.0	39,932.3
12	Сагил	14,155.0	7,815.7	635.0		2,025.0	685.7	470.0	4,000.0	
13	Тариалан	680.0	558.5			231.6	171.9		155.0	
14	Түргэн	8,420.0	6,920.0	2,000.0		2,250.0	1,170.0		1,500.0	
15	Тэс	4,250.0	3,879.0			1,875.0	1,554.0	450.0		
16	Ховд	12,069.5	6,905.0	1,985.0		1,500.0	3,120.0	300.0		
17	Хяргас	16,206.5	14,887.5	4,265.0	3,191.6	2,100.0	1,560.0	3,150.9	620.0	
18	Цагаанхайрхан	11,200.0	8,909.4	2,500.0			2,753.7	700.0	2,955.7	
19	Улаангом	46,155.0	42,358.0	20,965.0	15,000.0		5,360.0	1,033.0		
	Дүн	241,132.2	209,335.6	42,675.7	27,479.9	19,796.2	29,768.1	8,653.9	40,255.5	40,706.3

Эх сурвалж: Аудитын түүвэр, судалгаа




График 2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 2024 онд 241,132.2 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж 209,335.6 мянган төгрөгийн зарцуулсан байна. Үүнээс 20.4%-ийг мод тарих, тарьц суулгац худалдан авахад 19.5%-ийг арчилгааны огтлолт, бусад арга хэмжээнд, 19.2%-ийг ойн хортон шавжтай тэмцэх ажилд, 14.2%-ийг хяналт, шалгалт, ой хээрийн түймрээс сэргийлэхэд, 13.1%-ийг хашаа, хайс, арчилгаа, усалгаанд, 9.5%-ийг талбай тусгаарлалтад, 4.1%-ийг сургалт нөлөөллийн ажилд тус тус зарцуулсан байна.

Баруунтуруун сумын ЗДТГ-аас 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр Өндөрхангай сум дундын ойн ангитай “Сургалт, тарьц суулгац нийлүүлэх” гэрээ байгуулан 4,000.0 төгрөгийн төлбөрийг бүрэн шилжүүлсэн байна. Гэрээний дагуу сургалтыг 2024 онд гүйцэтгэсэн боловч тарьц суулгацыг хүлээлгэн өгөөгүй байсан ба аудитын явцад зөрчлийг арилгууллаа.

2.1.3. “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд тарихаар төлөвлөсөн модны 2023, 2024 оны гүйцэтгэл 8.8 хувьтай байна.

Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлд “Мод тарьж ургуулах ажлыг зохион байгуулах”, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт “Аймаг, нийслэлийн Засаг дарга бүх нийтээр мод тарих сарын ажлыг жил бүр зохион байгуулж, 16 насанд хүрсэн иргэн бүр нэг, аж ахуйн нэгж, байгууллага таваас доошгүй мод тарьж ургуулах, услах, арчлах бөгөөд өөрийн хүчээр гүйцэтгэх боломжгүй тохиолдолд зардлыг хандивлана”, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолын 16-д “Зориудаар ойжуулах, байгалийн сэргэн ургалтыг дэмжих замаар доройтсон ойг

нөхөн сэргээх, үр, суулгацын нөөц бүрдүүлэх, түймэр, хөнөөлт шавж, хууль бус мод
бэлтгэл зэргийг бууруулах ой хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх” гэж тус тус
заажээ.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд
аймгийн хэмжээнд 2022-2030 он хүртэл 20,000.0 мянган ширхэг мод тарихаар
төлөвлөн баталсан байна.

Хөтөлбөрийн хүрээнд сумдын хэмжээнд 12,741.1 мянга, ашиглалтын тусгай
зөвшөөрөлтэй ХХК-ууд, төсөл хөтөлбөрийн эх үүсвэр, хүчний байгууллагууд 7,258.9
мянган ширхэг мод тарихаар төлөвлөгөөнд тусгагдсан байна.

Увс аймгийн хэмжээнд 2022-2030 онд хүртэл тарих модны төлөвлөгөөг дараах
хүчин зүйлд үндэслэн хуваарилсан байна. Үүнд:

- Говь, хээрийн бүсийн хүнсний ногоо, жимс жимсгэнэ бүхий агро ойн аж ахуй
- Говь, хээрийн эмийн ургамал бүхий агро ойн аж ахуй
- Говь, хээрийн бүсийн малын тэжээл, хадлан бүхий агро ойн аж ахуй
- Говь, хээрийн бүсийн агро силво бэлчээрийн аж ахуй
- Говь, хээрийн бүсийн ойжуулалт
- Говь, хээрийн бүсийн голын татмын ойжуулалт
- Говь, хээрийн бүсийн нуур, хөв, цөөрмийн ойжуулалт
- Ойт хээрийн бүсийн ойжуулалт
- Байгалийн сэргэн ургалт
- Авто замын хамгаалалтын зурвас
- Төв, суурин, дэд бүтэц, уул уурхай, хүнд үйлдвэрийн цогцолборын хамгаалалтын зурвас
- Тариалангийн талбайн хамгаалалтын зурвас
- Ногоон байгууламж гэх мэт.

Хөтөлбөрийн хүрээнд 2023-2024 онд тарих модны төлөвлөгөө, гүйцэтгэл,
ургалтын хувь дараах байдалтай байна.

*Хүснэгт 12. Хөтөлбөрийн 2023-2024 онд тарих модны төлөвлөгөө, гүйцэтгэл, ургалтын
хувь*

(Тоо.ширхээ)												
№	Сумын нэр	2023 оны тарьсан модны төлөвлөгөө, гүйцэтгэл, ургалт			2024 оны тарьсан модны төлөвлөгөө, гүйцэтгэл, ургалт			2023-2024 оны нийт модны төлөвлөгөө	2023-2024 оны нийт модны гүйцэтгэл	2023-2024 оны нийт ургасан модны тоо	2023-2024 оны модны гүйцэтгэл ийн хувь	2023-2024 оны модны ургалтын хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Ургасан модны тоо	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Ургасан модны тоо					
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	Баруунтуруун сум	502,600	4,723	2,420	170,000	17,624	7,780	672,600	22,347	10,200	3.3%	45.6%
2	Бөхмөрөн сум	9,000	585	535	18,000	1,425	1,325	27,000	2,010	1,860	7.4%	92.5%
3	Давст сум	485,000	2,500	800	56,000	898	200	541,000	3,398	1,000	0.6%	29.4%
4	Завхан сум	25,000	1,340	1,200	48,000	1,220	900	73,000	2,560	2,100	3.5%	82.0%
5	Зүүнговь сум	25,000	880	660	24,000	3,572	2,858	49,000	4,452	3,518	9.1%	79.0%
6	Зүүнхангай сум	5,000	1,350	10	10,000	1,350	140	15,000	2,700	150	18.0%	5.6%
7	Малчин сум	5,000	2,000	1,800	66,000	1,500	800	71,000	3,500	2,600	4.9%	74.3%
8	Наранбулаг сум	22,600	6,450	6,250	118,000	1,328	1,100	140,600	7,778	7,350	5.5%	94.5%
9	Өлгий сум	5,000	851	157	42,000	5,835	525	47,000	6,686	682	14.2%	10.2%
10	Өмнөговь сум	9,000	3,200	3,200	22,000	1,600	500	31,000	4,800	3,700	15.5%	77.1%
11	Өндөрхангай сум	485,000	11,590	10,740	82,000	3,213	2,364	567,000	14,803	13,104	2.6%	88.5%
12	Сагил сум	5,000	3,563	1,263	114,000	1,020	1,020	119,000	4,583	2,283	3.9%	49.8%
13	Тариалан сум	72,600	2,374	2,374	58,000	8,550	8,550	130,600	10,924	10,924	8.4%	100.0%
14	Түргэн сум	494,600	2,310	1,650	128,000	102,200	82,000	622,600	104,510	83,650	16.8%	80.0%
15	Тэс сум	19,000	3,915	3,850	26,000	6,164	6,086	45,000	10,079	9,936	22.4%	98.6%
16	Хяргас сум	493,000	1,667	1,400	110,000	1,835	1,620	603,000	3,502	3,020	0.6%	86.2%
17	Ховд сум	27,000	800	200	18,000	1,610	250	45,000	2,410	450	5.4%	18.7%
18	Цагаанхайрхан сум	5,000	11,522	8,065	10,000	3,373	2,192	15,000	14,895	10,257	99.3%	68.9%
19	Улаангом сум	105,600	61,758	52,250	68,000	62,639	38,101	173,600	124,397	90,351	71.7%	72.6%
	Нийт	2,800,000	123,378	98,824	1,188,000	226,956	158,311	3,988,000	350,334	257,135	8.8%	73.4%

Эх сурвалж: Увс аймаг дахь Төрийн аудитын газрын нэгтгэсэн судалгаа

Хүснэгтээс харахад “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа”
хөтөлбөрийн хүрээнд 2023-2024 онд аймгийн хэмжээнд нийт 3 988 000 ширхэг мод
тарихаар төлөвлөж, гүйцэтгэлээр 350 334 ширхэг мод тарьж гүйцэтгэлийн хувь 8.8
хувьтай байна. Үүнээс 257 135 ширхэг мод хэвийн ургаж тарьсан модны ургалтын
хувь 73.4 хувьтай байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд 2023-2024 онд тарьсан модны гүйцэтгэлийн хувь багатай сумд, мэргэжлийн байгууллагуудаас тарьсан модны гүйцэтгэл хангалтгүй байгаад нөлөөлж буй хүчин зүйлс, цаашид гүйцэтгэлийг хэрхэн сайжруулах талаар бичгээр санал, тайлбар авсан.

Ирүүлсэн тайлбар, саналыг хүснэгтээр нэгтгэн харуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 13. Байгууллага, сумдын ирүүлсэн тайлбар санал

(Тоо.ширхэг)

Түүвэрт хамрагдсан сум болон байгууллагын ирүүлсэн тайлбар, саналын нэгтгэл														
№	Сум болон байгууллагын нэр	Төсөв, санхүү	Хүний нөөц	Усан хангамж	Арчилгаа хамгаалалт	Газар, хашаа, хайс	Цаг уурын, нөхцөл байдал	Техник, тоног төхөөрөмж	Сургалт, сурталчилгаа	Иргэдийн оролцоо, урамшуулал	Хяналт шинжилгээ, үнэлгээ, төрөөс баримтлах бодлого зохицуулалт	Хөрс, бордоо	Хууль, эрх зүй	Ойн хөнөөлт шавьж, хортон
1	Байгаль орчны газар	1	1	1	1				1	1				
2	Түргэн СДОА	1	1	1	1		1	1	2	1	1			
3	Малчин сум, Малчин СДОА	2	2	2		1		2						
4	Өндөрхангай сум, СДОА, ХХНЦТХГНХЗ	2			1	1								1
5	Улаангом сум	2	1		1	1						1		1
6	Баруунтуруун сум	1	1	1	1	1					1			
7	Завхан сум	1								1				
8	Зүүнговь сум	1	1	1		1	1	1				1		
9	Бөхмөрөн сум	1												
10	Тэс сум	1	1	1		1						1		
11	Өлгий сум	1	1	1	1	1								
12	Хяргас сум	1	1	1			1						1	
13	Наранбулаг сум	1		1				1					1	
14	Давст сум	1	1	1										
15	Сагил сум		1	1			1	1						
Нийт дүн		17	12	12	6	7	4	6	3	3	2	3	2	2

Эх сурвалж: Сум болон байгууллагуудаас ирүүлсэн тайлбар санал

Мэргэжлийн байгууллага, сумдын санал, тайлбарыг нэгтгэн дүгнэхэд гүйцэтгэлийн хувь бага байгаа нь төсөв санхүү, хүний нөөц, усан хангамж, усалгааны техник, тоног төхөөрөмж, арчилгаа, хамгаалалт, газар, хашаа зэрэг хүчин зүйлс дутагдалтайгаас голлон шалтгаалсан байна. Тухайлбал: Хүний нөөц дутагдалтайгаас сумдын байгаль хамгаалагчид модоо усалж арчлах, хамгаалах зэрэг ажлуудыг гүйцэтгэж байна.

Цаашид “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх гарц, арга замыг тодорхойлж бодлогын түвшинд дэмжлэг үзүүлж ажиллахыг аймгийн удирдлагуудад зөвлөлөө.

Түүнчлэн “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний Зорилт 2-т “Үр болон тарьц суулгацын нөөц бүрдүүлэх” гэж заажээ. Үүнд:

- Ойн сан бүхий газруудад ойн байнгын үрийн талбай тусгаарлах, арчлах
- Бортоготой тарьц, суулгац ургуулах ажлыг эхлүүлж, дэмжих, техник тоног төхөөрөмжөөр хангах.
- Мод үржүүлгийн газар байгуулж, тарьц, суулгацын нөөц бүрдүүлэх
- Бүс нутгийн онцлогт тохирсон тарьц суулгац, үр, алим жимсний шинэ сортыг нутагшуулах зорилгоор гадаад хамтын ажиллагааг сайжруулах

Өндөрхангай, Малчин, Түргэний сумын СДОА-ууд “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд 2023-2024 онд бэлтгэсэн тарьц суулгацын тоо дараах байдалтай байна.

Хүснэгт 14. “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд 2023-2024 онд бэлтгэсэн тарьц суулгацын тоо

(Тоо.ширхэг)

Ойн анги	Бэлтгэсэн тарьц суулгацын тоо /2023 он/	Бэлтгэсэн тарьц суулгацын тоо /2024 он/	2023-2024 онд бэлтгэсэн нийт тарьц суулгацын тоо
Өндөрхангай СДОА	10,100	10,100	20,200
Малчин СДОА	11,000	6,500	17,500
Түргэн СДОА	35,000	29,500	64,500
Нийт	56,100	46,100	102,200

Эх сурвалж: Сум дундын Ойн ангийн судалгаа

Хүснэгтээс харахад 2023-2024 онуудад Өндөрхангай сумын СДОА 20,200 ширхэг, Малчин сумын СДОА 17,500 ширхэг, Түргэн сумын СДОА 64,500 ширхэг нийт 102,200 ширхэг тарьц суулгац бэлтгэн ажилласан байна.

Аудитын баг холбогдох мэргэжлийн байгууллагын албан хаагчдын хамтаар хөтөлбөрийн хүрээнд 2023-2024 онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 3 төсөл, арга хэмжээ, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хийгдсэн 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтэй танилцаж, ажлын зураг авалт, тооллого хийсэн.

Түүнчлэн дээрх 5 төсөл, арга хэмжээний хүрээнд тарьсан модны тоо, ургалтын хувь хэмжээний талаар Байгаль орчны газраар дүгнэлт гаргуулсан.

Байгаль орчны газрын дүгнэлтээр улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн 3 төсөл, арга хэмжээний тарьсан модны амьдралтын хувь нь гэрээнд заасан хувь хэмжээнд хүрэхгүй байна. Иймд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А-96/71 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журам, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу нөхөн тарилт хийлгэж хүлээн авахыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж болголоо.

Аудитын явцад сум, байгууллагын тарьсан модыг хэсэгчилсэн тооллогод хамруулж, сумдын холбогдох албан тушаалтнаас мэдээ тайлан, судалгаа гаргуулан авч Байгаль орчны газарт өгсөн мэдээ тайлантай тулгахад тарьсан модны тоо зөрүүтэй байна.

Аудитын явцад Төрийн аудитын газарт сумдаас ирүүлсэн судалгааны дүн болон Байгаль орчны газрын нэгтгэсэн дүнг харьцуулж харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 15. Судалгааны дүн мэдээний тулгалт

(Тоо.ширхэг)

Нэгтгэл гаргасан газрын нэр	2023 оны тарьсан модны төлөвлөгөө, гүйцэтгэл, ургалт			2024 оны тарьсан модны төлөвлөгөө, гүйцэтгэл, ургалт			2023-2024 оны нийт модны төлөвлөгөө	2023-2024 оны нийт модны гүйцэтгэл	2023-2024 оны нийт ургасан модны тоо	2023- 2024 оны модны гүйцэтгэл ийн хувь	2023- 2024 оны модны ургалтын хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Ургасан модны тоо	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Ургасан модны тоо					
2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
Төрийн аудитын газрын судалгааны нэгтгэсэн дүн	2,800,000	123,378	98,824	1,188,000	226,956	158,311	3,988,000	350,334	257,135	8.8%	73.4%
Байгаль орчны газрын нэгтгэсэн аймгийн дүн	2,800,000	118,927	77,302	1,188,000	212,290	142,234	3,988,000	331,217	219,536	8.3%	66.3%
Зөрүү	-	4,451	21,522	-	14,666	16,077	-	19,117	37,599.0	0.5%	7.1%

Эх сурвалж: ТАГ-ын нэгтгэсэн судалгаа, БОГ-ын судалгаа

Хүснэгтээс харахад 2023-2024 онд сумд нийт тарьсан модны тоог 19 117 ширхэг, ургасан модны тоог 37 599 ширхгээр тус тус Байгаль орчны газарт зөрүүтэй тайлагнасан байна. Тухайлбал: Малчин, Өлгий, Өмнөговь, Өндөрхангай, Түргэн, Тэс, Хяргас, Ховд зэрэг сумын тарьсан модны тоо мэдээ зөрүүтэй байна.

Байгаль орчны газар сумдаас ирүүлсэн тайлан мэдээнд хяналт тавиагүйгээс шалтгаалж “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хэрэгжилт болон аймгийн хэмжээний тайлан, мэдээний дүн зөрөх, иргэд олон нийтийг буруу мэдээллээр хангах эрсдэл тулгарч болзошгүй байна.

Цаашид сумдаас ирүүлсэн тайлан мэдээг нягтлан, шалгаж хүлээн авч байхыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж болгов.

2.2 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хэрэгжилтийг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлсэн байна.

2.2.1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан байна.

Монгол Улсын Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт “Сум дундын болон сум, дүүргийн ойн анги нь дараах эрх, үүрэгтэй”, 18.3.10 дахь заалтад “Иргэдэд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийг түймрээс хамгаалах чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах”, Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолын 16-д “Зориудаар ойжуулах, байгалийн сэргэн ургалтыг дэмжих замаар доройтсон ойг нөхөн сэргээх, үр, суулгацын нөөц бүрдүүлэх, түймэр, хөнөөлт шавж, хууль бус мод бэлтгэл зэргийг бууруулах ой хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх” гэж тус тус заасан байна.

Энэ хүрээнд аймгийн Байгаль орчны газраас 2023, 2024 онуудад мод тарих, холбогдох бусад чиглэлээр сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан байна.

Хүснэгт 16. Сургалтад хамрагдсан төсөвт байгууллага, ААН, иргэдийн тоог

№	Сум, Байгууллагын нэр	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, хоёр живаа харгаа хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа					
		Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн ажил /2023 он/			Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн ажил /2024 он/		
		Сургалтын нэр	Оролцсон төсөвт байгууллага, ААН	Иргэдийн тоо	Сургалтын нэр	Оролцсон төсөвт байгууллага, ААН	Иргэдийн тоо
1	2	9	10	11	12	13	14
1	Байгаль орчны газар	"Хоёр живаа харгаа" хөтөлбөрийн хүрээнд мод, цэцэг, зүлэг тарих аргачлал	Насан туршийн боловсролын төв	25	"Хоёр живаа харгаа" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Баруунтуруун ЕБС, ЗДТГ	50
			Хилийн цэргийн 0245-р анги	70		Цагаанхайрхан сумын ЕБС, ЗДТГ	50
			Прокурорын газар	14		Зүүнговь сумын ЕБС, ЗДТГ	50
			Ус цаг уур орчны шинжилгээний төв	23		Тарьц, суулгац бэлтгэгчид	30

		Шүүх шинжилгээний хэлтэс	8			
		Хяргас сумын ЗДТГ	35			
		6	175		6	180

Эх сурвалж: Увс аймаг дахь Төрийн аудитын газрын нэгтгэсэн судалгаа

"Хоёр живаа харгаа" хөтөлбөрийн хүрээнд 2023 онд мод, цэцэг, зүлэг тарих аргачлал сэдэвт сургалтаар 6 байгууллага, 175 иргэнд сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулж, 2024 онд "Хоёр живаа харгаа" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах сургалтаар 150 иргэнд, ойчдын уулзалт, хэлэлцүүлэг нөлөөллийн ажлаар 30 иргэнд тус тус сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан байна.

Тайлант онуудад хөтөлбөрийн хүрээнд холбогдох төсөвт байгууллага, сумдын мод тарих, холбогдох бусад чиглэлээр байгууллага, ААН, иргэдийг соён гэгээрүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан байдлыг давхардсан тоо, өссөн дүнгээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 17. Төсөвт байгууллага, сумдын мод тарих, холбогдох бусад чиглэлээр байгууллага, ААН, иргэдийг соён гэгээрүүлэх сургалт, нөлөөллийн ажил

№	Сум, Байгууллагын нэр	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа					
		Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн ажил /2023 он/			Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн ажил /2024 он/		
		Сургалтын нэр	Байгууллага, ААН	Иргэдийн тоо	Сургалтын нэр	Байгууллага, ААН	Иргэдийн тоо
1	2	3	4	5	6	7	8
1	Өндөрхангай Ханхөхий нурууны УТХГНХЗ	ой хээрийн түймрээс сэргийлэх	5	45	мод тарьж ургуулах	8	120
2	Увс нуурын ай савын УТХГНХЗахиргаа	Ойн тухай хууль, Байгаль орчны багц хуулиуд, Мод тарих техник технологи	20	13,120	Ойн тухай хууль, Газар нутгийн тусгай хамгаалал, Мод тарих техник технологи	22	30,469
3	Өндөрхангай СДОА	Ой модоо хайрлан хамгаалъя, Ойн үнэ цэнэ, ойтой танилцах аялал, тарилт, тарих зааварчилгаа сургалт, Мод тарих уриалга	15	853	Тарьц суулгац тараах, тарилт, тарих зааварчилгаа сургалт, Мод тарих уриалга	13	712
4	Малчин СДОА	Модожсон мөчир бэлтгэх, тарилт, тарих зааварчилгаа сургалт	17	112	Байхгүй	-	-
5	Түргэн СДОА	Ойн тухай хууль, танайд мод таръя, цахим илтгэлийн уралдаан, харандаан мөчир тарих арга, стандарт суулгац төсөл, ойн арчилгаа ашиглалтын мэргэжлийн ангийн дадлага сургалт	32	1,095	Ойн тухай хууль, алтан хонх, Улаангом хотын ногоон байгууламж хэлэлцүүлэг, ойн талаар баримтлах бодлого илтгэл, танайд мод таръя, эрүүл ой-эртэч ирээдүй аян, Ойн ач холбогдол, мод тарих яагаад хэрэгтэй вэ, мод тарих арга сэдэвт сургалт, харандаан мөчир тарих арга, стандарт суулгац төсөл, ойн арчилгаа ашиглалтын мэргэжлийн ангийн дадлага сургалт	51	2,526
6	Баруунтуруун сум	Мод хэрхэн тарих вэ / Иргэний индэр/, мод тарих аргачлал	5	85	Мод тарих ач холбогдол	5	130

7	Бөхмөрөн сум	Тэрбум мод, Ногоон байгаль, Хоёр живаа харгаа	15	750	Тэрбум мод, Ногоон байгаль, Хоёр живаа харгаа	15	700
8	Давст сум	Мод тарихын ач тус, хэрхэн тарьж ургуулах, зааварчилгаа мэдээлэл, уриалга, ойн гал түймрийн эрсдэл, зөрчил гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө зэргийг цахим хэлбэрээр /10 удаа/, мод тарьж үзүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ өгөх.	16	122	Мод тарихын ач тус, хэрхэн тарьж ургуулах, зааварчилгаа мэдээлэл, уриалга, ойн гал түймрийн эрсдэл, зөрчил гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө зэргийг цахим хэлбэрээр, мод	10	100
9	Завхан сум	Байгаль хамгаалалд бидний оролцоо, Элсний нүүдэл	2	100	Цөлжилт, Хайрлая-Хамгаалъя	2	110
10	Зүүнговь сум	Говийн төгөл ЭКО клуб сурагчтай хамтран сурагчдын дунд тэмцээн уралдаан зохион байгуулах, Хөдөлмөр халамжийн чиглэлээр ажилгүй иргэдээр мод тариулах,	24	485	Аймгийн БО газрын мэргэжилтэнтэй хамтран хоёр живаа харгаа хөтөлбөрийн хүрээнд сургалт нөлөөллийн ажил хийсэн	38	330
11	Зүүнхангай сум	Мод тарих уриалга, тарьц суулгацын мэдээлэл,	4	65	Мод тарих аргачлал, ой хээрийн түймрээс сэргийлэх, хууль бус мод бэлтгэл,	4	65
12	Малчин сум	хууль сурталчлах аяны хүрээнд	7	150	хууль сурталчлах аяны хүрээнд	7	150
13	Наранбулаг сум	Ногоон сум	6	45	модоо өөрөө тарья	8	60
14	Өлгий сум	Мод тарьсны ач холбогдол	1	25	Мод тарихыг заасан	1	2
15	Өмнөговь сум	Уриалга, Хог биш мод тарья аян, Алим болон жимсний мод тарих сургалт	5	211	Модоо арчилж ургуулья	3	80
16	Өндөрхангай сум	Ойн тухай хууль, Байгаль орчны багц хуулиуд, Мод тарих техник технологи	20	415	Ойн тухай хууль, Байгаль орчны багц хуулиуд, Мод тарих техник технологи	20	158
17	Сагил сум	Ой хээрийн түймэр" түүнээс урьдчилан сэргийлэх, ЕБС-ын сурагчдад байгаль орчин, ой, ус агаар зэргээр сургалт хийсэн.	8	178	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, "Байгаль орчныг хамгаалах тухай", "Амьтны тухай", "Ойн тухай" "БОАЖ-ын сайдын Бугын эвэр түүж бэлтгэхийг түр хугацаагаар хориглох тухай тушаал" болон бусад холбогдох хууль тогтоомж	8	178
18	Тариалан сум	БО-ны тухай хууль	1	450	Нөхөрлөл багийн хурал	5	560
19	Түргэн сум	Тэрбум мод	7	172	Мод тарилт	7	179
20	Тэс сум	Тэрбум мод болон ойн талаар	21	1,500	Тэрбум мод болон ойн талаар	17	1,500
21	Хяргас сум	Мод тарих аргачлал	5	120	Мод тарих аргачлал	5	120
22	Ховд сум	Мод тарих аргачлал, ой хээрийн түймрээс сэргийлэх	12	85	Мод тарих аргачлал, ой хээрийн түймрээс сэргийлэх, хууль бус мод бэлтгэл	8	70
23	Цагаанхайрхан сум	Мод тарих аргачлал	5	140	Мод тарих зөвлөмж	5	135
24	Улаангом сум	Сургалт, тарьц суулгацын худалдаа, уулзалт хэлэлцүүлэг, эко парад	50	2,200	Сургалт, тарьц суулгацын худалдаа, уулзалт хэлэлцүүлэг, эко парад	50	1,595
Нийт			303	22,523		312	40,049

Эх сурвалж: Сумдын судалгаа

Төсөвт байгууллага, сумууд дараах сургалт, нөлөөллийн ажлыг голлон зохион байгуулж ажилласан байна. Үүнд:

- Ойн тухай хууль, Байгаль орчны багц хуулиудын талаар
- Тарьц суулгац бэлтгэх, тараах, тарих зааварчилгааны талаар

- Тэрбум мод, хоёр живаа харгаа хөтөлбөрийн талаар
- Мод тарих аргачлал, зааварчилгааны талаар
- Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хууль бус мод бэлтгэлийн талаар
- Тэрбум мод хөтөлбөрийн талаар соён гэгээрүүлэх тэмцээн уралдаан, аян зарлах гэх мэт

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолын 37-д “Мод тарих, арчлах, ургуулах чиглэлээр 1000-аас доошгүй сургагч багш бэлтгэж, орон даяар сургалт зохион байгуулж зорилтот хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх”, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн Зорилт 6-д “Үр, тарьц, суулгац, усан хангамж, мод үржүүлгийн газарт, арчилгаа, хамгаалалт хийх мэргэжлийн байгууллага, хүний нөөцийг нэмэгдүүлэх” гэж заасан байна. Үүнд:

- 6.1-д СДОА-ийн ойжуулагч, ойн техникчийн орон тоог нэмэгдүүлэх
- 6.2-д Мод тарих, арчлах, ургуулах мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх сургагч багш бэлтгэх
- 6.3-д Мод үржүүлгийн чиглэлээр ажиллах ААН байгууллагыг нэмэгдүүлэх ажлыг бодлогоор дэмжих
- 6.4-д Мод тарих, ойжуулалт нөхөн сэргээлтийн арга хэмжээний хүрээнд гэрээгээр ажиллах хүний нөөц бүрдүүлэх
- 6.5-д “Улаангом” политехник коллежид ойжуулагч мэргэжлээр сурч буй суралцагчдын тоог нэмэгдүүлэх

Байгаль орчны газар нь 2024 онд хөтөлбөрийн хүрээнд мод тарьж, арчилж ургуулах сургагч багшийн сургалтыг МУИС-ийн ойн хөтөлбөрийн багш доктор, профессор С.Гэрэлбаатар, доктор Э.Даваажав нарын удирдлага доор зохион байгуулсан байна. Тус сургалтад 19 сумдаас мод, бут, сөөгийн үр, тарьц, суулгац бэлтгэн нийлүүлэгч иргэд, байгаль хамгаалагч, улсын байцаагчид, эко клубын багш нар, УТХГНХЗ-ны төлөөлөл, сум дундын ойн ангиуд, ойн мэргэжлийн байгууллагын ойжуулагч, ойн инженерүүд, хүчний байгууллагын төлөөлөл, Улаангом Политехник коллежийн ойн ангийн оюутнууд, нийт 57 иргэн хамрагдсан байна.

Энэхүү сургалтаар мод тарих хөрсний шинж чанар, тарьсны дараах арчилгаа, хамгаалалт, мод үржүүлэх үр дүнтэй аргууд, цаг уурын онцлогт тохирсон мод тарих аргууд, үр бэлтгэх, хадгалах технологи, мод үржүүлгийн газрын талбайн зохион байгуулалт, хүлэмжийн хөрс боловсруулах, түүнд таригдах ургамлуудын онцлог зэрэг сэдвүүдээр онол, практик хослуулан сургалтыг зохион байгуулж, мэдлэг чадварыг дээшлүүлсэн байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 36-д “Мод тарих, арчлах, ургуулах, уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр ерөнхий, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөр төсөл, заавар, аргачлал боловсруулах, мод бэлтгэх боловсруулах үйлдвэрийн мэргэшсэн ажилтан бэлтгэх ажлыг зохион байгуулах” гэж заасны дагуу Улаангом Политехник коллеж нь “Ойн арчилгаа, ашиглалтын ажилтан” мэргэжлээр 2022 оноос элсэлт авч насанд хүрэгчдийн 1 жилийн сургалтын үйл ажиллагааг хосмог сургалтын аргаар зохион байгуулж ажиллаж байна.

Дээрх сургалтын хүрээнд “Ойн арчилгаа, ашиглалтын ажилтан” мэргэжлээр 2023 онд 20, 2024 онд 20, нийт 40 суралцагч төгссөн байна.

Хүснэгт 18. Улаангом Политехник коллежийн төгсөгчдийн тоо, мэдээ

(Тоо ширхэг)

Мэргэжлийн нэр	Нийт төгсөгчийн тоо статистик мэдээгээр	Нийт ажлын байртай болсон болон дараагийн түвшинд суралцаж байгаа төгсөгч	Ажлын байртай болсон төгсөгч														
			Бүгд	Эр	Эм	Мэргэжлээрээ ажиллаж байгаа төгсөгч			Эзэмшсэн мэргэжлээс өөр ажил эрхэлж байгаа төгсөгч			Өөртөө ажлын байр бий болгон ажиллаж байгаа төгсөгч			Гадаадын улсад ажил хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгч		
						Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм
БҮГД ДҮН	40	31	31	27	7	4	4	0	20	16	4	5	3	2	2	1	1
Ойн арчилгаа, ашиглалтын ажилтан /2022-2023/	20	17	17	15	5	2	2		10	7	3	4	2	2	1	1	
Ойн арчилгаа, ашиглалтын ажилтан /2023-2024 /	20	14	14	12	2	2	2		10	9	1	1	1		1		1

Эх сурвалж: Улаангом Политехникийн судалгаа

Хүснэгтээс харахад тайлант онуудад “Ойн арчилгаа, ашиглалтын ажилтан” мэргэжлээр нийт 40 хүн төгссөнөөс мэргэжлээрээ ажиллаж байгаа төгсөгч 4, эзэмшсэн мэргэжлээс өөр ажил эрхэлж байгаа төгсөгч 20, өөртөө ажлын байр бий болгон ажиллаж байгаа төгсөгч 5, гадаадын улсад ажил хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгч 2, нийт 31 төгсөгч хөдөлмөр эрхлэн ажиллаж байна.

Эндээс харахад тодорхой хэмжээнд мэргэжилтэн бэлтгэж байгаа боловч ажлын байр хангалтгүйгээс шалтгаалж төгсөгчид мэргэжлээрээ ажиллах нөхцөл боломж бүрдэхгүй байна.

2.2.2. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд ил тод мэдээлсэн байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх зарим арга хэмжээний 16-д “Зориудаар ойжуулах, байгалийн сэргэн ургалтыг дэмжих замаар доройтсон ойг нөхөн сэргээх, үр, суулгацын нөөц бүрдүүлэх, түймэр, хөнөөлт шавж, хууль бус мод бэлтгэл зэргийг бууруулах ой хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх”, 38-д “Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн нийтийн эрүүл мэндэд үзүүлэх ач холбогдол, нөлөөллийн талаар олон нийтэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах”, 39-д “Ойжуулалт, мод тарьж ургуулах асуудлыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, соён гэгээрүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах, ногоон хөгжлийн талаарх соёлын арга хэмжээг дэмжиж ажиллах” гэж заасан байна.

Энэ хүрээнд аймгийн Байгаль орчны газраас 2023, 2024 онуудад мод тарих болон холбогдох бусад чиглэлээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэж ажилласан байна. Мэдээллийн болон хүргэсэн хүний давхардсан тоог өссөн дүнгээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 19. Иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэсэн тоо, мэдээ

Мэдээлэл хүргэсэн хэлбэр	2023 он		2024 он	
	Мэдээллийн тоо	Мэдээлэл хүргэсэн хүний тоо	Мэдээллийн тоо	Мэдээлэл хүргэсэн хүний тоо
Цахим хуудас, FB хаяг	145	151,832	152	192,368
Орон нутгийн ТВ	2	30,500	2	42,580
Боршур, гарын авлага, тараах материал	200	200	520	520
Сонин сэтгүүл	1	27,520	-	-
Багийн хурал	1	60	-	-
Ногоон мэдээ нэвтрүүлэг	8	82,540		
Танхимын сургалт			4	180
Дүн	357	292,652	678	235,648

Эх сурвалж: БОГ-ын цахим хаяг, баримт материал

Цахим хэлбэрээр болон орон нутгийн телевизээр хүргэж байгаа мэдээлэл, нэвтрүүлэг зэрэг нь олон нийтэд илүү хүрсэн байна.

Тайлант онуудад сумдын мод тарих болон холбогдох бусад чиглэлээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэж ажилласан байдлыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 20. Мод тарих болон холбогдох бусад чиглэлээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэсэн тоо

№	Сум байгууллагын нэр	Мэдээлэл хүргэсэн хэлбэр	2023 он		2024 он	
			Мэдээл лийн тоо	Мэдээлэл хүргэсэн хүний тоо	Мэдээл лийн тоо	Мэдээлэл хүргэсэн хүний тоо
1	Ханхөхийн нурууны УТХГНХЗ	Цахим хуудас	3	2,300	2	3,500
2	Увс нуурын ай савын УТХГНХЗ	Цахим, гарын авлага, багийн хурал	245	21,271	659	48,532
3	Өндөрхангай СДОА	Цахим, ТВ, гарын авлага, багийн хурал	17	4,640	21	3,349
4	Малчин СДОА	Цахим, ТВ, гарын авлага, багийн хурал	29	1,700	13	500
5	Түргэн СДОА	Цахим хуудас, ТВ, Багийн хурал гарын авлага	59	5,748	59	18,231
6	Баруунтуруун сум	Цахим, гарын авлага, багийн хурал	8	68	5	120
7	Бөхмөрөн сум	Цахим, гарын авлага, багийн хурал	70	3,110	98	1,345
8	Давст сум	Цахим, гарын авлага, багийн хурал	14	865	16	522
9	Завхан сум	Цахим, гарын авлага, багийн хурал	20	630	31	830
10	Зүүнговь сум	Цахим, гарын авлага, багийн хурал	81	766	73	858
11	Зүүнхангай сум	Цахим, гарын авлага, багийн хурал	5	345	5	235
12	Малчин сум	Цахим, ТВ, гарын авлага, багийн хурал	11	1,850	12	2,050
13	Наранбулаг сум	Гарын авлага, багийн хурал	4	195	6	210
14	Өлгий сум	Цахим, гарын авлага, багийн хурал	7	90	21	737
15	Өмнөговь сум	Цахим, гарын авлага, багийн хурал	11	600	8	410
16	Өндөрхангай сум	Цахим, гарын авлага, багийн хурал	5	2,400	2	408
17	Сагил сум	Цахим, гарын авлага, багийн хурал, бусад	7	178	5	214
18	Тариалан сум	Цахим, гарын авлага, багийн хурал, бусад	27	3,500	19	3,010
19	Түргэн сум	Цахим, гарын авлага, багийн хурал, бусад	9	955	9	980
20	Тэс сум	Тараах материал, багийн хурал	25	1,500	28	1,600
21	Хяргас сум	Гарын авлага, багийн хурал	5	330	4	180
22	Ховд сум	Цахим, гарын авлага, бусад	21	1,725	18	1,117

23	Цагаанхайрхан сум	Цахим хуудас, гарын авлага	3	540	4	531
24	Улаангом сум	Цахим, ТВ, гарын авлага, багийн хурал	2,538	12,300	1,530	10,250
	Нийт		3,224	67,606	2,648	99,719

Эх сурвалж: Сумдын цахим хаяг, судалгаа, баримт материал

Сумд цахим болон багийн хуралд мэдээлэл хийх, гарын авлага тараах байдлаар иргэдэд дараах мэдээлэл ихэвчлэн хүргэсэн байна. Үүнд:

- Хавар намрын мод тарилт
- Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх
- Хууль бус мод бэлтгэл, хяналт шалгалтын талаар
- Ойгоос хэрэглээний болон түлшний мод авах талбай, хугацаа
- Ойн хортон шавжтай хийж буй тэмцэл, хорио цээр тогтоосон тухай
- Байгаль орчны болон ойн тухай хууль тогтоомжийг сурталчлах гэх мэт

БҮЛЭГ 3

“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЖ, ҮР ДҮНГ ТООЦОЖ БАЙГАА Ч АЙМГИЙН ИТХ-д ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА.

3.1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн үр дүн, хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлж, аймгийн ИТХ-д тайлагнаагүй байна.

3.1.1 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд сум, байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийсэн ч, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.

“Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн 5 дугаар зорилтод дараах байдалтай тусган байна. Үүнд:

1. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээг АЗДТГ, БОАЖГ, МХГ, СДОА, мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хамтран жил бүр хийнэ.
2. Төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилт бүрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээг АЗДТГ, БОАЖГ, СДОА хариуцан гүйцэтгэж, тайлангаа жил бүр ИТХ-аар хэлэлцүүлнэ.
3. Орон нутгийн хэмжээнд төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг сумын Засаг дарга, ЗДТГ, Байгаль орчны байцаагч, Байгаль хамгаалагч нар хариуцан гүйцэтгэж, тайлангаа аймгийн БОАЖГ-т ирүүлнэ.
4. Төлөвлөгөөний явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт өөрчлөлт, эрхзүйн зохицуулалт оруулж болно.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс аудитад хамрагдах онуудад мөрдөгдөж байсан Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны А/06 дугаар захирамжаар баталсан аргачлал”-ын дагуу сум, агентлагийн жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний үр дүнг үнэлж дүгнэхдээ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, ЗГ-ын Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хэрэгжилтийг нэг шалгуур үзүүлэлт болгон авч үзсэн байна.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 2024 оны үйл ажиллагааны үрд дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга, зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 3/546 дугаар албан бичгээр холбогдох газруудад хүргүүлсэн байна. Тус албан бичигт “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, эрчимжүүлэх талаар тусгаж зөвлөмж өгсөн байна.

Мөн аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс аудитад хамрагдах онуудад Монгол улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хагас бүтэн жилээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хэрэгжилтийг тайлагнан ажилласан байна.

Харин “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд сум, байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийсэн ч, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна. Цаашид хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэхийг зөвлөмж болголоо.

Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Хяналт шалгалтыг төрийн захиргааны төв болон төрийн захиргааны

байгууллага, орон нутагт хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага /цаашид “хяналт шалгалтын байгууллага” гэх/ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хийх бөгөөд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн гэж ангилна” гэж заасны дагуу аймаг, сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагчид ой, байгалийн ургамал, ойн баялаг түүж бэлтгэх, худалдаалах, тээвэрлэх байдалд урьдчилан сэргийлэх хяналт, шалгалтыг хийж, илэрсэн зөрчилд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1, Зөрчлийн тухай хуулийн 2.1-т зааснаар холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

Аймгийн ойн нөөц бүхий 15 сумын нутагт ой, ургамлын хууль бус зөрчил үйлдэгдэж болзошгүй 156 цэг, сум руу орох гарах 15 цэгт мод бэлтгэлийн үед байнгын хяналт тавьснаар 2023 онд 31, 2024 онд 23, нийт 54 зөрчил илэрсэнд дараах арга хэмжээ авч ажилласан байна.

Хүснэгт 21. Ойн чиглэлээр 2023-2024 онуудад хийсэн хяналт, шалгалтаар илрүүлсэн зөрчилд авсан арга хэмжээ

№	Зөрчил илэрсэн сум	Албан шаардлага, Зөвлөмж		Шийтгэлийн арга хэмжээ		Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн	
		2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он
1	Наранбулаг			1	1		
2	Хяргас		2	1		1	2
3	Өндөрхангай	5	2			1	3
4	Зүүнхангай						
5	Сагил					2	1
6	Түргэн	8	4			1	
7	Цагаанхайрхан	2					
8	Малчин	8	4				
9	Ховд					1	1
10	Тэс				1		
11	Тариалан				1		
12	Улаангом				1		
Нийт дүн		23	12	2	4	6	7

Эх сурвалж: БОАЖГ-ын судалгаа

Аймгийн хэмжээнд 2023 онд ойн чиглэлээр илэрсэн 31 зөрчлийн 23 зөрчилд албан шаардлага, зөвлөмж, 2 зөрчилд шийтгэлийн арга хэмжээ авч, гэмт хэргийн шинжтэй 6 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна. Шалгалтын хүрээнд 5,896.1 мянган төгрөгийн нөхөн төлбөр тавьж, 13.5 м³ модыг хурааж улсын орлого болгожээ.

Мөн 2024 онд илэрсэн 23 зөрчлийн 12 зөрчилд албан шаардлага, зөвлөмж, 4 зөрчилд шийтгэлийн арга хэмжээ авч, гэмт хэргийн шинжтэй 7 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна. Шалгалтын хүрээнд 4,933.5 мянган төгрөгийн нөхөн төлбөр тавьж, 11.3 м³ модыг хурааж улсын орлого болгожээ.

Аудитын явцад аймгийн Байгаль орчны хяналтын улсын байцаагч, сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагчдаас тулгамдаж буй асуудлын талаар тайлбар авахад Байгаль орчны салбарын хууль тогтоомжид зөрчил, түүнд авах арга хэмжээ, хариуцлагын хэлбэрийг хуульчилсны дагуу улсын байцаагч хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд арга хэмжээ авахдаа шийтгэлийн хуудас, зөрчлийн тэмдэглэл хөтөлж хариуцлага тооцдог байсан. Харин 2017 онд батлагдсан Зөрчлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд тус тус зааснаар Прокурорын байгууллагын зөрчлийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлж, бүртгэлийн дугаар авснаар шалгах ажиллагааг эхэлдэг

болсон. Мөн шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа зөрчлийн талаар тэмдэглэл хөтлөх, гэрч, хохирогч, холбогдогчоос мэдүүлэг авах, үзлэг хийх, шинжээч томилох, дүгнэлт гаргуулах, шийтгэлийн хуудас бичих, зөрчлийн хэрэг нээх тогтоол үйлдэх гэх мэт хуульд заасны дагуу олон төрлийн баримт бичиг бүрдүүлдгээс шалтгаалан цаг хугацаа алдах, зөрчилд холбогдогчийг мэдэгдэх хуудсаар дуудахад ирэхгүй байх зэрэг хүндрэл учирдаг байна.

Иймд салбарын онцлогийг харгалзан үзэж, зөрчилд авах арга хэмжээг хялбар байдлаар, техникийн дэвшилтэд технологи ашиглах, үйлдсэн зөрчил тодорхой, нотлох баримт ил зөрчлийг газар дээр нь хариуцлага тооцох хэлбэрт шилжүүлэх шаардлагатай байгаа талаар санал ирүүлсэн. Тус асуудлыг хууль тогтоомжид өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх шаардлагатай байна.

Сумдын ИТХ-аас Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний төсвийг батлагдахаа хяналт шалгалтын зардлыг тусган баталж өгсөн байна.

Хүснэгт 22. Ойн чиглэлээр 2023- 2024 онд хийсэн хяналтад зарцуулсан төсөв

(Мянган төгрөг)

№	Сумын нэр	2023 он		2024 он	
		БОХНСАХ-ний төлөвлөгөө	Хяналтад зарцуулсан төсөв	БОХНСАХ-ний төлөвлөгөө	Хяналтад зарцуулсан төсөв
1	Баруунтуруун	17,487.1		19,975.0	2,225.0
2	Бөхмөрөн	7,153.5	4,403.5	1,967.0	567.0
3	Давст	6,797.0	450.0	5,727.5	775.0
4	Завхан	-		-	
5	Зүүнговь	560.0		495.0	
6	Зүүнхангай	9,800.0	153.5	13,904.2	220.0
7	Малчин	28,018.9		12,795.2	940.4
8	Наранбулаг	9,033.1	1,261.7	5,000.0	910.9
9	Өлгий			-	
10	Өмнөговь	-		5,780.0	
11	Өндөрхангай	22,000.0	9,920.0	62,352.3	
12	Сагил	19,317.2	1,107.2	14,155.0	685.7
13	Тариалан	1,248.9	800.9	680.0	171.9
14	Түргэн	10,936.0		8,420.0	1,170.0
15	Тэс	5,476.3	1,623.2	4,250.0	1,554.0
16	Ховд	7,270.6	1,622.9	12,069.5	3,120.0
17	Хяргас	16,830.9	3,680.9	16,206.5	1,560.0
18	Цагаанхайрхан	3,000.0		11,200.0	2,753.7
19	Улаангом	28,922.0	625.0	46,155.0	5,360.0
Дүн		193,851.5	25,648.8	241,132.2	22,013.6

Эх сурвалж: Сумдын ИТХ-ын тогтоол, БАНАТ-ын судалгаа

Сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчид хяналт хэрэгжүүлэхдээ 2023 онд 25,648.8 мянган төгрөг, 2024 онд 22,013.6 мянган төгрөгийг тээвэр шатахууны зардалд зарцуулсан байна.

3.1.2. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн үр дүнг тооцсон ч аймгийн ИТХ-д тайлагнаагүй байна.

Тайлант онуудад хавар, намрын мод тарилт хийгдсэний дараа сумууд мод тарих чиглэлээр зохион байгуулсан ажлын тайлан болон тарьсан модны тоог Байгаль орчны газарт ирүүлсэн байна. Байгаль орчны газрын холбогдох албан тушаалтан аймгийн хэмжээний мод тарилтын нэгдсэн мэдээг гаргаж, бичмэл тайлангийн хамт Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар болон аймгийн Засаг даргад жилд 2 удаа хүргүүлж хэвшсэн байна.

БОГ-ын мэргэжилтэн Ойн газарт мэдээ, тайлан хүргүүлэхдээ forest.gov.mn системийг ашиглаж маягтын дагуу дараах тайлангуудыг хүргүүлдэг байна. Үүнд:

- Ойн нөхөн сэргээлт, таримал ой
- Ойн ашиглалт, мод бэлтгэл,
- Хортон шавжийн хяналт
- Түймрийн бүртгэл

Мөн жилийн эцсийн тайлангаа байгууллагын цахим хуудаст байршуулсан байна.

“Хоёр живаа харгаа” хөтөлбөр нь 2030 он хүртэл 3 үе шаттай хэрэгжихээр батлагдсан байна.

- I үе шат - 2022-2024 он хүртэл. Энэ хугацаанд хөтөлбөрийн бэлтгэл ажлыг хангаж, ажлыг эхлүүлэх, тарьц суулгацын нөөцийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна
- үе шат- 2024-2028 он хүртэл. Энэ хугацаанд мод тарьж ургуулах, ойжуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.
- үе шат - 2028-2030 он хүртэл. Энэ хугацаанд тарьсан модыг арчлах, ургалт, өсөлтийг дэмжих ажлууд

Хөтөлбөрийн 1-р үе шат 2024 онд дууссан тул хэрэгжилт, үр дүнг тооцож цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэх шаардлагатай байна. Аймгийн ИТХ-ын ажлын албанаас ирүүлсэн 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 230 дугаар албан бичигт “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хэрэгжилтийг хурлын хуралдаанаар тусгайлан хэлэлцээгүй...” гэж дурдсан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 7/04 дүгээр тогтоолын 3-т “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн биелэлт, үр дүнг нэгтгэн жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж байхыг аймгийн Засаг даргад даалгасугай гэж заажээ.

Мөн хөтөлбөрийн 5.2-т “Төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилт бүрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээг АЗДТГ, БОАЖГ, СДОА хариуцан гүйцэтгэж, тайлангаа жил бүр ИТХ-аар хэлэлцүүлнэ”, 8-д “Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайлан мэдээг аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Байгаль орчин аялал жуулчлалын газар холбогдох газруудаас нэгтгэж, хяналт шинжилгээ үнэлгээг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэстэй хамтран зохион байгуулж үр дүнг жил бүр гарган, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд бүтэн жилээр танилцуулж байна” гэж заасны дагуу хөтөлбөрийн биелэлт, үр дүнг нэгтгэн аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэхийг холбогдох албан тушаалтанд зөвлөмж болголоо.

3.2. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд бий болсон хөрөнгө, тарьц суулгацыг нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн ч тарьсан модыг цахим системд бүрэн бүртгээгүй байна.

3.2.1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2 дахь заалтад “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасан байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд улсын төсөвт байгууллагын ойн чиглэлийн үйл ажиллагаа, орон нутгийн хөгжлийн сан, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ, орон нутгийн хөрөнгө оруулалтын хүрээнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд дараах байдлаар тусгасан байна.

Хүснэгт 23. Хөрөнгийн нягтлан бодох бүртгэлд тусгасан байдал

(Мянган төгрөг)

№	Сум, Байгууллагын нэр	2023 оны хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгасан дүн		2024 оны хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгасан дүн	
		Хөрөнгө материалаар бүртгэсэн дүн	Урсгал зардлаар хүлээн зөвшөөрсөн	Хөрөнгө материалаар бүртгэсэн дүн	Урсгал зардлаар хүлээн зөвшөөрсөн
1	2	3	4	5	6
1	Аймгийн ЗДТГ	205,241.1	-	198,098.1	
2	Байгаль орчны газар		2,047.0		5,354.8
3	Өндөрхангай ханхөхий нурууны УТХГНХЗ		14,000.0		11,000.0
4	Увс нуурын ай савын УТХГНХЗахиргаа		986.2		2,303.7
5	Өндөрхангай СДОА	18,015.0	900.0	13,773.0	450.0
6	Малчин СДОА		11,064.1	2,700.0	6,017.4
7	Түргэн СДОА		37,197.2	5,350.0	49,661.0
8	Баруунтуруун сум	9,750.0	6,830.0		19,975.0
9	Бөхмөрөн сум	5,760.0	7,153.5	19,850.0	2,147.0
10	Давст сум	46,999.00	21,424.30		5,341.90
11	Завхан сум		5,700.0	-	-
12	Зүүнговь сум		8,000.0		31,840.0
13	Зүүнхангай сум	89,350.0	1,183.7	2,468.0	9,452.2
14	Малчин сум	38,400.0	2,618.9	4,500.0	15,295.2
15	Наранбулаг сум		2,761.7	3,000.0	10,170.9
16	Өлгий сум	2,640.0	360.0		
17	Өмнөговь сум				4,760.0
18	Өндөрхангай сум		9,920.0	19,920.0	39,932.3
19	Сагил сум	3,315.0	3,874.1	635.0	7,180.7
20	Тариалан сум	-	8,390.0	5,245.1	5,261.4
21	Түргэн сум	-	9,500.0	-	6,920.0
22	Тэс сум	59,413.0	4,493.2	3,600.0	3,879.0
23	Хяргас сум		26,270.6	24,937.5	
24	Ховд сум	2,090.0	2,672.9	1,985.0	4,920.0
25	Цагаанхайрхан сум	3,000.0	-	8,909.4	
26	Улаангом сум		13,290.0	35,465.0	17,893.0
	Нийт	483,973.1	200,637.4	350,436.1	259,755.5

Эх сурвалж: Увс аймаг дахь Төрийн аудитын газрын нэгтгэсэн судалгаа

Хөтөлбөрийн хүрээнд 2023 онд зарцуулсан 684,610.5 мянган төгрөгөөс 483,973.1 мянган төгрөгийг хөрөнгө, бараа материалаар бүртгэж, 200,637.4 мянган төгрөгийг урсгал зардлаар, 2024 онд зарцуулсан 610,191.6 мянган төгрөгөөс 350,436.1 мянган төгрөгийг хөрөнгө, бараа материалаар бүртгэж, 259,755.5 мянган төгрөгийг урсгал зардлаар тус тус бүртгэсэн байна.

Өндөрхангай, Малчин, Түргэн сумын СДОА-ууд тайлант онуудад хүлээн авсан үндсэн хөрөнгийн дүн дараах байдалтай байна.

Хүснэгт 24. Сум дундын ойн ангиуд тайлант онуудад үндсэн хөрөнгөд бүртгэсэн дүн

(Мянган төгрөг)

Ойн анги	Нэмэгдсэн хөрөнгө /2023 он/		Нийт 2023 онд нэмэгдсэн хөрөнгө	Нэмэгдсэн хөрөнгө /2024 он/		Нийт 2024 онд нэмэгдсэн хөрөнгө
	Төсвийн хөрөнгөөр	Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө		Төсвийн хөрөнгөөр	Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө	
Өндөрхангай СДОА		170,869.5	170,869.5		25,053.2	25,053.2
Малчин СДОА	937.4		937.4	1,100.0	41,043.6	42,143.6
Түргэн СДОА	6,200.0	139,045.8	145,245.8	10,250.0	72,495.1	82,745.1

Эх сурвалж: Аудитын түүвэр, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй

Өндөрхангай сумын СДОА нь 2023 онд ойн газраас KFW төслийн хүрээнд 94,524.9 мянган төгрөгийн трактор, 44,520.9 мянган төгрөгийн техник хэрэгсэл, сумын Засаг даргын тамгын газраас 31,823.7 мянган төгрөгийн хүлэмж, хүлэмжийн газар, нийт 170,869.5 мянган төгрөгийн хөрөнгө, 2024 онд 25,053.2 мянган төгрөгийн техник, хэрэгслийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газраас ирүүлснийг нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байна.

Малчин сумын СДОА нь 2023 онд 937.4 мянга, 2024 онд 1,100.0 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 41,043.6 мянган төгрөгийн хөрөнгийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газраас ирүүлснийг нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байна.

Түргэн сумын СДОА нь 2023 онд 6,200.0 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авч, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газраас KFW төслийн хүрээнд 94,524.9 мянган төгрөгийн трактор, 44,520.9 мянган төгрөгийн техник хэрэгслийг үнэ төлбөргүй хүлээн авч, нийт 145,245.8 мянга, 2024 онд 10,250.0 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авч, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газраас KFW төслийн хүрээнд 24,397.0 мянга, Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 48,098.1 мянга нийт 82,745.1 мянган төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байна.

Харин Улаангом сумын ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдсэн “Хурандаа цогцолбор /ХЦ0245-р анги/” төсөл, арга хэмжээний хүрээнд техникийн тодорхойлолтод заагдсаны дагуу гүйцэтгэгч Чандмань Хархираа ХХК хайлаас 88, гоёлын мод 33, нийт 121 ширхэг мод суулгасныг ажлын хэсэг хүлээн авсан байна. Аудитын явцад 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар тооллого хийхэд 75 ширхэг мод нь хэвийн амьдралтай байна.

Мөн Улаангом сумын Засаг даргын тамгын газар нь гүйцэтгэгчээс ирүүлсэн алдаатай зарлагын баримтыг үндэслэн 435 модыг дансанд бүртгэж авсан байна. Иймд модны нөхөн тарилтыг гүйцэтгэгч компаниар хийлгэж, бүртгэлд зөрүүтэй тусгасан 314 ширхэг модыг данснаас хасахыг холбогдох албан тушаалтанд зөвлөмж болголоо.

3.2.2. Иргэн, ААН, байгууллагуудын тарьсан модыг улсын нэгдсэн санд бүртгэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.


Ойн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ойн төлөв байдал, ойн сангийн эзлэх талбайн хэмжээ, нөөц, бүрэлдэхүүн, үнэлгээ, тэдгээрийн өөрчлөлт, ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний талаарх цогц мэдээллийг агуулсан улсын хэмжээний ойн мэдээллийн сантай байна”, 6.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 6.1-д

заасан мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн долдугаар бүлэгт заасны дагуу зохицуулна”, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 1-д “Улсын мэдээллийн сан дараахь зүйлийн талаархи мэдээллээс бүрдэнэ”, 4-д “Ой”, 44 дөрөвдүгээр зүйлийн 3-д “Иргэн, хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр цуглуулж бүрдүүлсэн өгөгдөл, мэдээллийн тухай мета мэдээллийг улсын санд төлбөргүй өгөх үүрэгтэй”, 5-д “Иргэн, байгууллага, хуулийн этгээд нь улсын төсөв, шинжлэх ухаан, технологийн сан, олон улсын болон гадаадын зээл, тусламжийн хүрээнд бүрдүүлсэн байгаль орчны өгөгдөл, мэдээллийг улсын мэдээллийн санд үнэ төлбөргүй төвлөрүүлэх үүрэгтэй” гэж заасан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн 1.5-д “Иргэн, аж ахуйн нэгжийн тарьсан модоор ойн санг бүрдүүлж, түүнийг улсын нэгдсэн санд бүртгэх, тарьсан модыг зах зээлийн эргэлтэд оруулж энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулахад нь бодит дэмжлэг үзүүлэх болон гадаад улсаас Монгол Улсад ирж буй хүн бүр Монгол оронд мод тарих санаачилгыг өрнүүлэх”, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний 35-д “Модны үр, тарьц, суулгац, тарьсан модны тоо, талбайн хэмжээг нэгдсэн мэдээллийн санд оруулах” гэж заасан байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар 2023 оны 01 дүгээр сараас эхлэн Terbummod.mn сайтыг бүтээсэн байна.

Terbummod.mn сайтад Байгаль орчны газрын ойжуулалт, нөхөн сэргээлт хариуцсан мэргэжилтэн модны үр, тарьц, суулгац, тарьсан модны тоо, талбайн хэмжээг нэгтгэн оруулснаар улсын хэмжээний нэгдсэн дүнд нэгтгэгдэж олон нийтэд мэдээлэх зорилгоор ашиглаж эхэлсэн байна.



Энэхүү сайтад мэдээлсэн модны тоо зөрөх, шивсэн мэдээ хадгалагдахгүй байх зэрэг алдаа гарч байсан тул 2023 онд шинэчлэл хийсэн байна.

Үүний үр дүнд Terbummod.mn сайт нь иргэн, аж ахуй нэгж байгууллага тарьсан мод, бэлтгэсэн суулгацаа бүртгүүлэх, мод тарих хүсэлт илгээх, ханган нийлүүлэгчийг сонгох бүрэн боломжтой болжээ.

Зураг 1. Terbummod.mn сайтад

Цаашид сайтын үйл ажиллагааны талаар иргэн, аж ахуйн нэгжийг мэдээллээр хангаж ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөлөө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Холбогдох баримт бичигт нийцүүлэн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг орон нутагт хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг баталсан байна.
2. Ой бүхий сумдын ойн менежментийн төлөвлөгөөг аймгийн Засаг дарга батлаагүй байна.
3. “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд 2023, 2024 онд улс, орон нутгийн төсвөөс баталсан 1,562.3 сая төгрөгийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.
4. “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд 2023, 2024 онд тарихаар төлөвлөсөн модны гүйцэтгэл 8.8 хувийн биелэлттэй байна.
5. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн 404.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний хүрээнд тарьсан модны амьдралтын хувь нь гэрээнд заасан хувь хэмжээнд хүрэхгүй байна.
6. Байгаль орчны газрын нэгтгэл тайланг сумдаас ирүүлсэн судалгааны дүнтэй харьцуулахад тарьсан модны тоо зөрүүтэй байна.
7. Хөтөлбөрийн хэрэгжилтийг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлж, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулсан байна.
8. “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн үр дүнг тооцож аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаагүй байна.
9. “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвөөс зарцуулсан хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хөтөлбөрийн үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.
10. Хурандаа цогцолбор /ХЦ0245-р анги/ төсөл арга хэмжээний хүрээнд тарьсан модны ургалт хангалтгүй, модны тоог данс бүртгэлд зөрүүтэй тусгасан байна.
11. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын тарьсан модыг улсын нэгдсэн санд бүртгэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



УВС АЙМАГ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165
Утас: 7045-2012, 7045-2315 Факс: 7045-4095
Цахим шуудан: info@uvs.gov.mn
Цахим хуудас: www.uvs.gov.mn

2025. 10. 31 № 3 / 1686

танай _____ -ны № _____ -т

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд 2023-2024 онд улс, орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Аудитын тайланд оруулах санал байхгүй, зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллана.

ДАРГА  У.ГАНЗОРИГ

D disk: AZDTG- tamga-5
8525021770



**УВС АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР**

5 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85169

Утас: 7045-3176

Цахим шуудан: uvsnature@gmail.com

2025.10.31 № 305
танай _____ -ны № _____ -т

**УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Танай газраас ирүүлсэн “Тэрбум мод”
үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа хөтөлбөр”-
ийн хүрээнд 2023-аас 2024 онд улс, орон нутгийн
төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүнд
хийсэн аудитын тайлангийн төсөлтэй санал нэг
байгаа бөгөөд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж
ажиллах болно.

ДАРГА  Б.ЭНХТУЯА



8525180317

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд 2023-2024 онд улс, орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүн сэдэвт аудитын тайлангийн төсөлд:

Аймгийн ЗДТГ-ын 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 3/1686 дугаар албан бичгээр “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд 2023-2024 онд улс, орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайланд тусгах санал байхгүй болно.

Байгаль орчны газар 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 305 дугаар албан бичгээр “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн хүрээнд 2023-2024 онд улс, орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй санал нэг байна”, гэсэн хариу ирүүлсэн тул тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

1. Ой бүхий сумын ойн менежментийн төлөвлөгөөг батлах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавих.
2. “Хоёр живаа харгаа” хөтөлбөрийн биелэлт, үр дүнг нэгтгэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар жил бүр хэлэлцүүлэх.

Байгаль орчны газарт:

1. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн 3 төсөл, арга хэмжээг гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу нөхөн тарилт хийлгэж хүлээн авах.
2. Тайлан мэдээг үнэн зөв гаргаж мэдээлэх.

Улаангом сумын Засаг даргад:

1. Хурандаа цогцолбор /ХЦ0245-р анги/ төсөл арга хэмжээний хүрээнд тарьсан модны нөхөн тарилтыг гүйцэтгэгч компаниар хийлгэж, бүртгэлд зөрүүтэй тусгасан 314 ширхэг модыг данснаас хасах.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Б.АВИРМЭД

Р.АЮУШ

Т.БАТСҮХ

Увс аймаг, Улаангом-85160,
Засаг даргын тамгын газрын байр Утас:70453317
И-мэйл: uvs@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn